

ҮНДЭСНИЙ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ИРГЭНИЙ ЁС ЗҮЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР: БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D.), Д.Аюуш, Г.Алтан-Оч (Ph.D.),
Б.Батцэцэг, Д.Жигваагүнсэл, И.Жаргалзаяабямба,
Р.Оргилмаа, Б.Мөнгөнсүвд*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

НЭГ. ОНОЛ, АРГА ЗҮЙ, МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

- 1.1. “ЁС ЗҮЙ”-Н ТАЛААРХ ОНОЛ, АРГА ЗҮЙ
- 1.2. МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ (“ИРГЭНИЙ ЁС ЗҮЙН
БОЛОВСРОЛ” СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР)

ХОЁР. ҮНДЭСНИЙ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН
ИРГЭДЭД ЁС ЗҮЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ХӨТӨЛБӨРИЙН ТАЛААРХ
БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

- 2.1. БҮГД НАЙРАМДАХ СИНГАПУР УЛС
- 2.2. БҮГД НАЙРАМДАХ ЭСТОНИ УЛС
- 2.3. ЯПОН УЛС
- 2.4. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС
- 2.5. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС
- 2.6. БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛС
- 2.7. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

УИН.МН
СУДАЛГААНЫ САН

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүн, УИХ-ын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны даргын захиалгаар “Үндэсний соён гэгээрүүлэх үйл ажиллагаа ба иргэний ёс зүйн хөтөлбөр: бусад орнуудын туршлага” сэдэвт харьцуулсан судалгааг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Гадаадын зарим орны үндэсний хэмжээний соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, иргэний ёс зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр баримталж буй бодлого, хөтөлбөрүүд болон практик үйл ажиллагааны талаарх туршлагыг харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд Сингапур, Эстони, Япон, Солонгос, Казахстан, Энэтхэг, Герман зэрэг улсуудыг хамруулан үндэсний соён гэгээрүүлэх бодлого, тогтолцоо, иргэний ёс зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд болон холбогдох эрх зүйн зохицуулалт, практик туршлагыг харьцуулан судалсан болно.

Судалгааны бүтэц: Судалгаа нь хураангуй болон үндсэн хоёр хэсэгтэй бөгөөд үндсэн хэсгийн эхний хэсэгт ёс зүйн талаарх онол, арга зүй болон Монгол Улс дахь иргэний ёс зүйн боловсролын сургалтын хөтөлбөрийн талаар авч үзсэн бол дараагийн хэсэгт үндэсний соён гэгээрүүлэх үйл ажиллагаа ба иргэний ёс зүйн хөтөлбөрийн талаарх бусад орнуудын туршлагыг оруулав.

Түлхүүр үг: Үндэсний соён гэгээрүүлэх хөтөлбөр, иргэний ёс зүйн хөтөлбөр, сургуулийн ёс зүйн хөтөлбөр

Key words: *national enlightenment program, citizen ethics program, school ethics curriculum*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хүний нийгмийн амьдрал нь өөрийн оршихуй болох зан суртахуунаар тодорхойлогддог. Тийм учраас зан суртахууны асуудал нь түүхийн аль ч цаг үед нийгмийн янз бүрийн анги, бүлэг, эрдэмтэн мэргэдийн анхаарлын төвд судлагдан иржээ.

Платоноос эхлээд Карл Маркс хүртэлх олон философичид ёс зүйг сайн сайхан амьдралын үзэл баримтлалын үндэс болгож, хувь хүний эрүүл хөгжлийн онолыг боловсруулж ирсэн. Эдгээр философичдын гол үзэл санаагаар жинхэнэ сайн сайхан амьдралд хүрэх зам нь хүний дотоодод орших, сайтар зохион байгуулагдсан, эрүүл саруул сэтгэхүйг бүрдүүлэх явдал байв. Эдгээр үзэл санааг өнөөдөр ч гэсэн философич, сэтгэл зүйчид судалсаар, хөгжүүлсээр байна.

Судалгаанд авагдсан Сингапур, Эстони, Япон, Солонгос, Казакстан, Энэтхэг, Герман зэрэг улсуудын бүх нийтийг соён гэгээрүүлэх бодлого ба энэ хүрээнд хэрэгжүүлж буй иргэдэд чиглэсэн ёс зүйн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоо, эрх зүйн орчин болон практик туршлагыг судлан үзэхэд тухайн улс орны түүхэн уламжлал, онцлог байдал, одоогийн хөгжлийн түвшин зэрэгтэй нягт холбоотой, хэрэгжүүлэх арга барил нь дээрхээс хамааран харилцан адилгүй байна.

Нийтлэг байдлаар авч үзвэл, судалгаанд авагдсан орнуудад бүх нийтийг соён гэгээрүүлэх хөтөлбөр болон иргэдэд олгох ёс зүйн боловсролыг бага, балчир наснаас нь буюу бага, дунд боловсролын шатнаас эхлэн системтэйгээр олгож байна. Энэ үйл ажиллагааг тухайн улсын засгийн газар, холбогдох яам, агентлаг, сургалтын байгууллагууд хариуцан хэрэгжүүлж байгаа бөгөөд иргэний нийгмийн байгууллагууд ч мөн энэ үйл хэрэгт хувь нэмрээ оруулан хамтран ажиллаж байна.

Судалгаанд авагдсан орнуудын туршлагыг тоймлон авч үзвэл:

Судалгаанаас үзэхэд, Япон, Энэтхэг зэрэг эртний соёл, иргэншилтэй, өөрийн гэсэн өвөрмөц ёс уламжлалтай орнуудын хувьд тухайн үндэстний өөрсдийн гэсэн ёс зүйн зарчим, шашин, зан заншлын болон эрх зүйн системтэй уялдуулсан бодлоготой байгаа бол Эстони, Сингапур зэрэг улсуудад тухайн улсын иргэнийг төлөвшүүлэх, ёс зүйн чиг баримжаа олгох үйл ажиллагааг сургалтын тусгайлсан хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлдэг байна.

Тухайлбал, Өмнөд Солонгос Улсад иргэний боловсролын асуудлыг нийт 120 гаруй хууль тогтоомжоор зохицуулж байгаа бөгөөд эдгээрээс *Насан туршийн боловсролын тухай хууль*, *Сургуулийн өмнөх боловсролын*

тухай хууль, Бага, дунд сургуулийн боловсролын тухай хууль гэх мэт гол гол хууль тогтоомжоор бүх нийтийн суурь боловсрол, иргэнийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохицуулж байна.

Монгол Улсын хувьд Монгол Улсын Засгийн газар, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайдын “Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай” 2019 оны А/390 дүгээр тушаалаар “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр батлагдаж улмаар өмчийн хэлбэр үл харгалзан ерөнхий боловсролын сургуулийн сурагчид 2019-2020 оны хичээлийн жилээс судалж эхэлсэн байна. **“Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр** нь Монгол Улсын “Үндсэн хууль”, “Бага, дунд боловсролын тухай хууль”-ийг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах үндсэн зорилготой бөгөөд Монгол Улсад амар амгалан, хүмүүнлэг нийгмийг бүтээх, сургууль, анги хамт олон, гэр бүлд эелдэг найрсаг уур амьсгал бүрдүүлэх, сурагчдад ёс зүйн боловсрол олгоход чухал ач холбогдолтой гэж үзжээ.

(Судалгааны үр дүнгийн харьцуулалтыг *Хүснэгт 1-ээс үзнэ үү.*)

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хүснэгт 1. Судалгаанд авагдсан орнуудын хөтөлбөр ба тогтолцооны талаарх харьцуулсан хүснэгт

Улс	Хөтөлбөр	Тогтолцоо
Сингапур	“Ёс зүй, иргэний боловсрол” (Civics and Moral Education) сургалтын хөтөлбөр нь “Үнэт зүйлийг хэвшүүлэх” (Values in Action) буюу “Нийгэм дэх хувь хүний оролцоо хөтөлбөр” (Community Involvement Programme) болон “Үнэт зүйлийг төлөвшүүлэх” (Values in Practice) зэрэг дэд хөтөлбөрүүдийг багтаадаг байна.	Боловсролын яам (Ministry of Education)-аас үндэсний хэмжээнд ард иргэдээ соён гэгээрүүлэх, ёс зүйн боловсрол олгох, хүмүүнлэг, идэвхтэй, оролцоотой иргэн бэлтгэх, үндэсний үнэт зүйлээ өвлүүлэн хадгалуулах зорилгоор “Ёс зүй, иргэний боловсрол хөтөлбөр” (Character and Citizenship programme)-ийг бага наснаас нь Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрөөр олгодог байна. Тус хөтөлбөр нь “Иргэний болон ёс суртахууны боловсрол”, “Үндэсний боловсрол” болон сургуулийн танхимаас гадуур хүүхэд бүрийн заавал хамрагдах боловсролын хөтөлбөрүүдээс бүрдсэн сургалтын цогц хөтөлбөрийг хэлнэ.
	Иргэншлийн сургалтын хөтөлбөр (Singapore Citizenship Journey) нь жил бүр зохион байгуулдаг байна. Сургалтаар Сингапурт суурьшихаар зорин ирсэн хүмүүст тус улсын түүх, хөгжлийн гол үе шатууд, Сингапурчуудын нийгмийн хэм хэмжээ, үнэт зүйлсийн талаарх мэдлэгийг гүнзгийрүүлэн олгохын сацуу тухайн орон нутгийнхаа аж байдалтай танилцах, дасан зохицоход нь тусалдаг байна. Сургалт нь цахим сургалтын модулиуд, туршлага судлах хөтөлбөр, олон нийттэй харилцах гэсэн хэсгүүдээс бүрддэг. Сургалтын төгсгөлд албан ёсны арга хэмжээ зохион байгуулан, сургалтад хамрагдагсдыг Сингапур Улсын иргэн болсныг албан ёсоор мэдэгдэн, Иргэний бүртгэлийн үнэмлэх (National Registration Identity Card)-ийг гардуулдаг байна.	2001 онд Тарту их сургуулийн философийн факультетын бүрэлдэхүүнд “ Ёс зүйн төв ”-ийг салбар хоорондын уялдаа холбоог судлах зорилгоор байгуулж, улмаар 2009 онд концерцум болгон өргөжүүлсэн. Тус төв нь эхлээд их дээд сургуулиудын нийгмийн болон иргэний боловсрол, ёс зүйн хичээлүүдийн агуулгыг тодорхойлох, энэ чиглэлээр лекц, гарын авлагыг бэлтгэх зэргээр хязгаарлагдмал хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байсан бол 2009 оноос олон нийтэд зориулсан танин мэдэхүйн үйл ажиллагаа, сургалт, салбар мэргэжлийн ёс зүйн дүрмийг боловсруулах, судалгаа, дүн шинжилгээ хийх, ёс зүйн хичээл, сургалтын багш нарыг бэлтгэх ажлыг тус тус явуулдаг болсон.

<p>Эстония</p>	<p>Энэхүү сургалтын үндэсний хөтөлбөрийг хичээл хоорондын уялдаа холбоог Ирэнэий боловсролд чиглүүлэх, ардчилсан ёсонд суурилсан сургуулийн ач холбогдлыг чухалчлах зорилгоор 2002 онд шинэчлэн боловсруулжээ.</p> <p>Харин 2011 оны хөтөлбөрийн шинэчлэлээр дунд сургуулийн дунд болон ахлах ангиудад заах хичээлийн хөтөлбөрийг тодорхой ялган боловсруулах гэх зэргээр сургалтын хэт их ачааллын асуудлыг шийдвэрлэхийг оролдсон.</p> <p>Улмаар нийгмийн болон иргэний ур чадвар хэмээх хэт ерөнхий ур чадварын сургалтыг практик амьдралын ач холбогдол бүхий агуулгаар солих үүднээс 2014 оны хөтөлбөр шинэчлэлтийг дахин хийсэн байна. Үүнд иргэний ур чадварыг Европын боловсрол, сургалтаар олгох гол түлхүүр ур чадварууд гэх зэргээр Европын Холбооны бодлогын бичиг баримтуудад зааснаар тодорхойлжээ. Ийнхүү урьд өмнөх үндэстэн төвтэй хандлага нь зөөлөрч, дэлхий нийтийн ардчиллын болон Европын үнэ цэнийг эрхэмлэх хандлага нь нэлээд өссөн байна.</p> <p>Японд 1890 онд Эзэн хааны боловсролын тухай гаргасан зарлигаас эхлээд Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Нийгмийн боловсролын тухай хууль зэрэгт ёс зүй, ёс суртахууны талаар нарийвчлан тусгаж өгчээ.</p> <p>Боловсролыг дэмжих үндсэн төлөвлөгөө 2023 он (Basic Plan for the Promotion of Education) Нийгмийн боловсролд чиглэсэн асуудлаар энэ удаагийн төлөвлөгөөнд:</p> <ul style="list-style-type: none">• Тогтвортой нийгмийг дэмжих – Ирээдүйн нийгэм бүтээгчдийн санаачлагатай байдал, манлайлал, бүтээлч байдал, асуудлыг зөв шийдвэрлэх чадвар, логик сэтгэлгээ, өөрийгөө илэрхийлэх чадвар, үнэт зүйлсээ тодорхойлох чадварыг сайжруулах тал дээр олон ажлыг эрчимжүүлэх• Өв соёлоо дээдлэн сайн сайхан амьдралын хэв маягийг сайжруулах – Эрүүл мэнд, аюулгүй орчин, насан туршийн боловсролыг нийгмийн боловсролоор дамжуулан түгээх гэсэн 2 зорилт тавин шат шатны байгууллагуудад уг зорилтыг хэрэгжүүлэхийг тусгажээ. <p>Япон Улсын хувьд боловсролд оруулсан хувь хөрөнгө оруулалтыг хувь хүнд бус нийгмийн хөгжлийн үндэс гэж үздэг байна. Тиймээс ирээдүйн симбиотик нийгмийг хөгжүүлэх, шинэ үеийн үнэ цэнийг болгох тал дээр маш их анхаарч байна.</p>
<p>Орчин үеийн боловсролын тогтолцоо үүссэн цагаас “Ёс зүйн хичээл”-ийн хөтөлбөрийг тогтвортой баримталж, гэр бүл, сургууль, нийгмийн орчинд нэгдмэл байдлаар тусгаж ирсэн.</p> <p>Ерөнхий боловсролын сургуульд ёс суртахууны хичээлийг дараах 4 төрлийн агуулгад тулгуурлан заадаг.</p> <ol style="list-style-type: none">1. Өөрийнхөө тухай: Хүн бүр бие даасан байх, өөрсдийн хийж чадах зүйлээ хийх, хэм хэмжээтэй амьдрах;2. Бусад хүмүүстэй харилцах харилцаа: Хүмүүстэй шударга харилцах, хүмүүстэй эелдэг харилцах;3. Байгаль, эрхэм дээд зүйлтэй харилцах: Байгалийн гамшиг, байгаль, амьтны ач холбогдлыг мэдрэх;4. Нийгэм болон бүлгүүдийн тухай: Олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, дүрэм журмаа дагах, амлалтаа биелүүлэх.	

<p>Солонгос</p>	<p>Солонгос Улсад иргэдийн ёс зүй, боловсролын асуудлыг Үндсэн хуулиас гадна нийт 120 гаруй хууль тогтоомжоор зохицуулдаг бөгөөд эдгээрээс дараах хууль тогтоомж болон бусад хуулиар бүх нийтийн суурь боловсрол, иргэдийг соён гэгээрүүлэх арга хэмжээг Насан туршийн боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Бага, дунд сургуулийн боловсролын тухай хууль гэх мэт гол хууль тогтоомжоор зохицуулж байна.</p> <p>БНСУ-ын анхны бие даан баталсан Ёс зүй, ёс суртахууны ухагдахуун нь 1950-иад онд анх сургалтын хөтөлбөрт тусгагдсан бөгөөд цаг үе, нийгмийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагатай уялдан хэд хэдэн удаа өөрчлөгдсөн байна.</p> <p>2000 оноос буюу одоо мөрдөгдөж буй 7 дугаар сургалтын хөтөлбөрт “ethnic identity” (үндэсний ондоошил) гэх олголт их орсон байна. 7-10 дугаар ангийн ёс зүйн хичээлийн сурах бичгийн агуулгад дараах 4 хүрээг хамруулсан байна.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хувийн амьдрал; 2. Гэр бүл, хөрш, сургууль дахь амьдрал; 3. Нийгмийн амьдрал; 4. Үндэсний болон хамт олны амьдрал 	<p>Боловсролын тогтолцоо</p> <p>БНСУ-ын боловсролын систем нь бага сургууль, дунд сургууль, ахлах сургууль, их, дээд сургууль, мэргэжлийн дээд сургууль гэсэн тогтолцоотой байдаг бөгөөд дараах байдлаар суралцах жил, хичээлийн хөтөлбөрийг зохицуулсан байдаг.</p> <ul style="list-style-type: none"> • Бага сургууль – 6 жил • Дунд сургууль – 3 жил • Ахлах сургууль – 3 жил <p>Шинэ хөтөлбөрийн хүрээнд бага сургуулийн 1 дүгээр ангиас ахлах сургуулийн 1 дүгээр анги (1-10 дугаар анги)-ийн үндсэн хөтөлбөрөөр хичээллэх бол ахлах сургуулийн 2-3 дугаар анги (11-12 дугаар анги)-д сурагчид өөрсдийн ирээдүйн зорилго, зорилтод нийцүүлэн сурах хичээлүүдээ сонгон суралцах юм.</p>
<p>Казахстан</p>	<p>Казахстан Улсын хувьд ёс зүйн үндсийг Аль-Фарабигийн гурвалжингаар тайлбарладаг бөгөөд “үнэнч зан чанар”, “шударга ёс”, “цэвэр сэтгэл” гэх гурван хэсгээс бүрддэг байна. Энэ гурван зүйл хүн бүрд байх ёстой гэж үздэг.</p> <p>Эрдэмтэн Аль-Фарабигийн “Их хотын оршин суугчид” хэмээх зохиолд ёс суртахууны үндэс болсон 12 шинж чанарыг “Оюунлаг үндэстэн-2020” хөтөлбөртэй уялдуулж, оюутан, сурагчдын хөгжлийг төлөвшүүлэх, сэтгэн бодох чадварыг дээшлүүлэх, үзэл санаатай нийцүүлдэг байна.</p> <p>Казахстан Улсын хувьд хүүхэд, залуучуудын хүмүүжил төлөвшил, ёс суртахууны боловсролын тухай тусдаа хууль байхгүй, харин хөтөлбөр хэрэгжүүлдэг.</p> <p>Хөтөлбөрийг Казахстан Улсын боловсролын системд нэвтрүүлснээр “Өөрийгөө танин мэдэх” хичээлийн хөтөлбөрийг бий болгож, 2010 оноос эхлэн хэрэгжүүлсэн.</p> <p>Хөтөлбөрийн зорилго нь хүний дотоод ертөнцийг нээснээр зөв боловсон хүн болж төлөвшихөд дэмжлэг үзүүлэх, эрхэм дээд чанарт сургах, амьдрах чадвар болон боломжийг хөгжүүлэхэд оршино. Түүнчлэн бодол санаа, үг яриа, үйл хөдлөлөө зөв уялдуулах, ямар ч асуудлыг өөрийн болон бусдын тусын тулд оновчтой шийдэх, эх оронч үзлийг төлөвшүүлэх, хүний эрхийг хүндэтгэх чадварыг эзэмшүүлэх зорилготой.</p>	<p>Бүгд Найрамдах Казахстан Улсын Боловсролын яам (Ministry of Education of Republic of Kazakhstan) нь төрийн нэгдсэн бодлогоор иргэн бүрийг чанартай боловсрол эзэмших эрхээр хангах бөгөөд Боловсролын тухай хууль (Law of on Education), Улсын боловсролын дааж мөрдөх стандарт (State Mandatory Standards of Education)-ыг үндэслэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Үндэсний хэмжээнд ёс суртахуун, оюун ухааны боловсролын “Өөрийгөө танин мэдэх” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.</p>

Энэтхэг	<p>Бүх нийтийн ёс зүйн боловсрол (Universal Ethics Education-UEE)- Энэ хөтөлбөр нь Дээрхийн Гэгэнтэн XIV Далай Ламын айлдсан нийтээр мөрдөх ёс суртахууны үзэл баримтлал дээр үндэслэсэн хөтөлбөр юм. Хөтөлбөрийн хүрээнд байгууллага болон олон нийтийн орчинд хүүхэд, залуучуудад зориулсан ёс зүйн сургалтыг боловсруулан хэрэгжүүлдэг. Хамрах хүрээний хувьд хүүхэд (4-14 насны хүүхэд), багш, эцэг эх, олон нийтийн байгууллага зэрэг хүрээнд явагддаг.</p> <p>Иргэний дүрэм- Тус дүрэм нь төрөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, стандартын талаарх үүрэг болон иргэдийн ёс зүй, ёс суртахууны талаарх харилцан ойлголцлын баримт бичиг юм.</p> <p>Гандигийн ёс зүй- Махатма Гандигийн төрсөн өдөр буюу 10 дугаар сарын 02-ны өдрийг Энэтхэгийн ард түмэн үндэсний баяр болгон тэмдэглэж, Гандигийн сургаал, зарчим, номлолыг хойч үедээ дэлгэрүүлэн түгээдэг байна. Гандигийн 11 зарчим өнөөдөр ч Энэтхэг гэлтгүй дэлхий даяар олон сая хүмүүсийг чиглүүлж, урам зориг өгсөөр байна.</p>	<p>Бүх нийтийн ёс зүйн боловсрол (Universal Ethics Education-UEE) Энэ хөтөлбөр нь 2014 онд боловсруулагдаж эхэлсэн бөгөөд 2017 онд дунд ангийн сурагчдад хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн бол 2018 онд орон нутгийн сургуулиудад, 2019 онд бага ангийн сурагчдад хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн байна. Энэ хөтөлбөрийг засгийн газраас дэмжиж, хэрэгжүүлдэг.</p> <p>Иргэний дүрэм- Энэхүү дүрмийн үзэл баримтлалын анх Их Британид 1991 онд үндэсний хөтөлбөр болгон хэрэгжүүлсэн бөгөөд 1997 онд Энэтхэгийн засгийн газар засгийн газрын хөтөлбөр болгон хэрэгжүүлсэн байна.</p>
Герман	<p>Дотоод сэтгэлийн боловсролыг олгох тухай тусгайлан зохицуулсан хууль, дүрэм хэдийгээр байхгүй ч ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт ёс зүй, ёс суртахуун болон зан суртахуун ба иргэний боловсролын хичээлийн агуулгад тусгагдсан гэж үзэж болохоор байна. Дээрх хичээлүүд нь суралцагч, өсвөр үе, залуучууд өөрсдийн эрх, эрх чөлөөгөө мэдэж, шийдвэр гаргах үйл явцад оролцох, байр сууриа илэрхийлэх чадвараа хөгжүүлэхэд туслах, оролцоо бүхий нийгмийн хариуцлагатай гишүүн болон төлөвшихөд нь дэмжлэг үзүүлэх, залуучуудын ёс суртахууны ухамсар, ёс суртахууны зан байдлыг хөгжүүлэхэд чиглэж байна.</p>	

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

НЭГ. ОНОЛ, АРГА ЗҮЙ, МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

1.1. “ЁС ЗҮЙ”-Н ТАЛААРХ ОНОЛ, АРГА ЗҮЙ

Хүний нийгмийн амьдрал нь өөрийн оршихуй болсон зан суртахуунаар тодорхойлогддог. Тийм учраас зан суртахууны асуудал нь түүхийн аль ч цаг үед нийгмийн янз бүрийн анги бүлэг, эрдэмтэн мэргэдийн анхаарлын төвд судлагдан иржээ.

Зан суртахууны тухай мэдлэг эртнээс үүсэж хөгжсөн бөгөөд түүнийг “ёс зүй”-н ухаан судалдаг байна. Ёс зүй нь эртний грекийн “ethos” гэдэг үгнээс гаралтай байна. Энэ нь анх “хамтран амьдрах байр, аж төрөх” гэсэн утгатай байсан бөгөөд сүүлдээ хүмүүсийн амьдралын ямар нэг үзэгдэл, ёс заншил, зан суртахуун, зан төлөв, сэтгэлгээний хэв маяг гэсэн ойлголтыг өгөх болсон билээ.

Ёс зүйн тухай мэдэгдэж байгаар эртний Грек, Ромын сэтгэгчид болох Демократ, Сократ, Платон, Аристотелийн үе (НТӨ V-II зуун)-ээс судлагдаж эхлээд эртний Энэтхэг, Хятадын үзэл, сургаалаар дамжиж дундад зууны үеийн шашны ёс зүйгээр нөхцөлдөж, орчин үеийн ёс зүйн зарчим, онолын арга зүй бүрджээ.

Орчин үеийн ёс зүйн ойлголт

18-р зууны Германы философич И.Кант шинжлэх ухааныг өөрийнхөө протестант хүмүүжлийн зан суртахууны хатуу шаардлагын зарчимтай зохицуулж, зан суртахууны үндсэн зарчмуудыг учир зүйн хувьд үндэслэхийг оролдсон. Философичид ёс зүйн тухай ярихдаа үнэн хэрэгтээ бие биенээсээ огт ондоо гурван асуудлыг гаргаж тавьдаг. Энэ нь:

1. Би өөрийнхөө зан суртахууны зарчмыг үнэн зөв гэдэгт хэрхэн итгэж үнэмших ёстой вэ?
2. Зан суртахууны үүднээс үзэхэд их хүнд хэцүү асуудлыг хэрхэн шийдвэрлэж болох вэ?
3. Хэрхэн сайн сайхан амьдарч болох вэ?

Кант ямар ч нөхцөлд бүх хүний хувьд туйлын бүрэн зөв зарчим болох Категорик императив гэж нэрлэгдсэн зан суртахууны зарчмыг гаргаж хэрэглэсэн. Харин ийм түгээмэл үйлчилдэг зарчим байна гэдгийг ёс зүйн релятивизм болон ёс зүйн скепицизм хоёр үгүйсгэдэг. Хүнд хэцүү тохиолдлыг шийдвэрлэхийн тулд утилитаризмын төлөөлөгчид болох Иеремия Бентам, Жон Стюарт Милль нар хамгийн их олон хүмүүст хамгийн Их Аз Жаргал өгөх зарчмыг гаргаж ирсэн. Утилитаризм бол зан суртахууны ба орчин үеийн философийн хамгийн их маргаантай онолын нэг мөн юм.

Платоноос эхлээд Карл Маркс хүртэлх олон философичид сайн сайхан амьдралын үзэл баримтлалын үндэс болгож хувь хүний эрүүл хөгжлийн онолыг боловсруулж байсан. Эдгээр философичдын гол үзэл санаа бол жинхэнэ сайн сайхан амьдралд хүрэх зам нь хүний дотоодод сайн зохион байгуулагдсан, эрүүл саруул сэтгэцийг бүрдүүлэх явдал байв. Энэ үзэл санаануудыг өнөөдөр ч гэсэн философич, сэтгэл зүйчид судалсаар байна.

1.2. МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ (“ИРГЭНИЙ ЁС ЗҮЙН БОЛОВСРОЛ” СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР)

Монгол Улсын Засгийн газар, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайдын “Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай” 2019 оны А/390 дүгээр тушаалаар “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр батлагдаж, улмаар 2019-2020 оны хичээлийн жилээс өмчийн хэлбэр үл харгалзан ерөнхий боловсролын нийт сургуулийн сурагчдад хэрэгжиж эхэлсэн байна.

“Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр нь Монгол Улсын “Үндсэн хууль”, “Бага, дунд боловсролын тухай хууль”-ийг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах үндсэн зорилготой бөгөөд Монгол Улсад амар амгалан, хүмүүнлэг нийгмийг бүтээх, сургууль, анги хамт олон, гэр бүлд эелдэг найрсаг уур амьсгал бүрдүүлэх, сурагчдад ёс зүйн боловсрол эзэмшүүлэх чухал ач холбогдолтой.

Иргэний ёс зүйн боловсрол хичээлийг бага ангид нийт 320 цаг, дунд ангид нийт 264 цаг, ахлах ангид нийт 198 цаг орохоор сургалтын төлөвлөгөө батлагдан хэрэгжиж байна.⁸⁰

Сургалтын хөтөлбөрийн зарчим, зорилго, зорилт

Зарчим: Сургалтын хөтөлбөрийг бага ангийн сурагч монгол хүн болж төлөвших суурь мэдлэг, чадвар, дадал эзэмших; дунд ангийн сурагч монгол иргэн болж хүмүүжих; ахлах ангийн сурагч эх орныхоо эзэн (монгол хүн) болж төлөвших зарчим баримтлан, сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилтыг тодорхойлж, агуулга, арга зүй, үнэлгээг боловсруулсан байна. Үүнд:

- Монголын уламжлалт өв соёлын мөн чанарыг танин мэдэж, түүнээс суралцах, амьдралдаа хэрэгжүүлэхэд хөтлөх;
- Монгол хүний амьдралын бодит байдлыг судлах;
- Агуулга нь ёс зүй, ёс суртахууны талаарх ухагдахуун, ойлголтоос бүрдэх төдий биш, ёс зүйн боловсрол эзэмших арга ухааныг өөрөө бүтээхэд чиглэх;

⁸⁰ <https://cdn.greensoft.mn/uploads/users/2649/files/Curriculum/EBS/iregnii-yos-zui-1-5-angi.pdf> “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр, удирдамж

- Сурагчийн нас, сэтгэцийн онцлог, эрэлт хэрэгцээнд нийцсэн байх;
- Ихийг гүехэн биш, багыг гүнзгий судлах;
- Анги ахих тусам өргөжин гүнзгийрэх;
- Залгамж холбоог сайтар хангах зэрэг болно.

Зорилго: Сургалтыг хүнлэг энэрэнгүй, цэвэр ариун сэтгэлтэй, билэг оюун төгөлдөр, уламжлалт ёс заншил, ахуйгаа таньж мэдсэн, хүндэлж хамгаалдаг, монгол үндэстнийхээ хэл, соёл, ёс заншлыг эзэмшсэн, бахархаж хэрэглэдэг, бие, хэл, сэтгэлээрээ сайн үйл хийдэг, эх орон, улс үндэстнээ эрхэмлэн дээдлэх үүрэг, хариуцлагаа ухамсарласан, хүмүүнлэг нийгмийг цогцлоон байгуулах ирээдүйн монгол иргэнийг бэлтгэхэд оршино.

Зорилт:

- Сурагч ёс зүйн хэм хэмжээг танин мэдэж, ёс суртахууныг эзэмших
- Уламжлалт сурган хүмүүжүүлэх ухааны арга, аргачлалын учир утгыг танин мэдэж, сурч судлах үйлдээ мөрдөх;
- Өөрийн гэсэн зөв үзэл бодолтой болж, түүндээ тууштай байж, үзэл бодлоо баталж нотолж чаддаг байх;
- Бие, хэл, сэтгэлээр үйлдэх сайн үйлийг зуршил болгож, муу үйлийг цээрлэн жигших;
- Хүмүүнлэг нийгмийг бүтээн байгуулахыг эрмэлзэх, хүн, нийгэм, байгаль орчинтой зөв харилцах, нийгмийн үйл хэрэгт ухаалгаар, идэвхтэй оролцох;
- Бусад хүнийг болон төр улс, эх орон, хүн төрөлхтнийг хүндлэхийн учир утгыг ойлгож, ухааран хүндлэх;
- Амьдралын зорилгоо зөв тодорхойлж, түүнд зөв аргаар хүрэх, бие даан амьдрах арга ухаанд суралцах;
- Сурч судлах, хөдөлмөрлөх, бүтээх үйлд шамдах, чин сэтгэлээсээ хандах;
- Гэр бүл, анги хамт олон, бусад хүний болон нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагаа сайтар ухамсарлах;
- Асуудлыг ёс суртахууны хувьд зөв, оновчтой шийдвэрлэх, бэрхшээлийг даван туулах үүргээ ухамсарлаж, зорилго нэгтэй, эв эетэй байж, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах, улмаар дэлхийд байр сууриа эзлэх иргэн болж хүмүүжих;
- Айх, ичих ухамсартай, ичгүүр сонжууртай байх;
- Санаа бодлоо нээлттэй илэрхийлж, бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандах;
- Хойч үеийнхээ өмнө хүлээх үүрэг, хариуцлагаа гүн тогтсон хэв ёс, заншил, төрийн хууль, дэг журмыг баримталдаг иргэн болж төлөвших.

ХОЁР. ҮНДЭСНИЙ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ИРГЭДЭД ЁС ЗҮЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ХӨТӨЛБӨРИЙН ТАЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

2.1. БҮГД НАЙРАМДАХ СИНГАПУР УЛС

Сингапур Улсын Боловсролын яам (Ministry of Education)-аас үндэсний хэмжээнд ард иргэдээ соён гэгээрүүлэх, ёс зүйн боловсрол олгох, хүмүүнлэг, идэвхтэй, оролцоотой иргэн бэлтгэх, үндэсний үнэт зүйлээ өвлүүлэн хадгалуулах зорилгоор “Ёс зүй, иргэний боловсрол хөтөлбөр” (Character and Citizenship programme)-ийг бага наснаас нь Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрөөр олгодог байна. Тус хөтөлбөр нь “Иргэний болон ёс суртахууны боловсрол”, “Үндэсний боловсрол” болон сургуулийн танхимаас гадуур хүүхэд бүрийн заавал хамрагдах боловсролын хөтөлбөрүүдээс бүрдсэн сургалтын цогц хөтөлбөрийг хэлнэ.⁸¹

Соёл, олон нийт, залуучуудын яам (Ministry of Culture, Community and Youth), Үндэсний нэгдмэл байдлын зөвлөл (National Integration Council), Ард түмний нийгэмлэг (People's Association) болон Сингапур Улсын цагаачлал, шалган нэвтрүүлэх газар хамтран Сингапур Улс руу цагаачлан ирсэн иргэдийг Сингапур Улсын түүх, соёл, үнэт зүйлс, ёс суртахуун, нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлага зэрэг иргэн бүрийн зайлшгүй мэдвэл зохих агуулгыг багтаасан сургалт, хөтөлбөрт тодорхой заасан хугацаагаар заавал хамруулдаг байна.

Сингапур Улс нь үндэснийхээ үнэт зүйлийг хүүхэд багачууддаа өвлүүлэх, хүнлэг, энэрэнгүй, ёс суртахуунтай иргэдийг хүмүүжүүлэх зорилгоор 1950-аад оны сүүл үеэс ёс зүйн албадан боловсролыг иргэний, ёс зүйн, шашны боловсролоор дамжуулан олгож эхэлсэн байна.

“Иргэний болон ёс суртахууны боловсрол” хөтөлбөр

1992 оноос Боловсролын яамнаас “Иргэний болон ёс суртахууны боловсрол” (Civics and Moral Education) ёс зүйн боловсролын шинэчилсэн хөтөлбөрийг боловсруулан, Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангийн сурагчдад зааж эхэлсэн байна. Тус шинэчлэгдсэн хөтөлбөр нь иргэний боловсролд илүүтэй анхаарч дараах 5 үнэт зүйлийг тодорхойлон, хөтөлбөртөө багтаасан. Үүнд, олон нийтийн аливаа асуудлыг өөрийн асуудлын өмнө тавих, гэр бүлийг нийгмийн үндсэн тулгуур гэж үзэх, хувь хүний эрхийг хүндэтгэн үзэж, олон нийтээс дэмжлэг үзүүлэх, асуудлыг зөрчилдөх бус зөвшилцлийн аргаар шийдвэрлэх, арьс өнгө, шашин шүтлэгээр ялгаварлахгүй байх зэрэг болно.

⁸¹ <https://www.nlb.gov.sg/main/article-detail?cmsuuiid=99663443-930d-418e-b010-4718d0ad7543>

“Үндэсний боловсрол” хөтөлбөр

Сингапурын бусад улс үндэстнээс ялгарах онцлог, тус улсын түүхэн замнал, ололт амжилт болон анхаарах асуудлууд, Сингапур Улсын үнэт зүйлсийн нэгт тооцогддог шатлан дэвших шударга зарчим, үндэстэн ястнуудын таарамж, нийцэл зэргийг хүүхэд, багачуудад зааж сургах, танин мэдүүлэх замаар үндэсний нэгдмэл байдал, түүний ач холбогдлын талаар сургах, төлөвшүүлэх зорилготой “Үндэсний боловсрол” (National Education)⁸² хөтөлбөрийг 1997 оноос эхлүүлсэн байна. Тус хөтөлбөрийг мөн Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрөөр дамжуулан олгох болжээ. “Үндэсний боловсрол” хөтөлбөр нь сургалтын олон төрлийн үйл ажиллагааг хамарсан, дараах зорилготой:

- Хүүхэд багачуудад Сингапур Улсын түүх, өнөөгийн хүрсэн түвшин, ололт амжилт, бахархал, үндэстний хувьд тулгарч буй сорилыг танин мэдүүлэх, цаашид оршин тогтнох, итгэл үнэмшлийг төлөвшүүлэх, мэдлэгтэй, ур чадвартай иргэн бэлтгэх;
- Өөртөө итгэлтэй, хүсэл эрмэлзэлтэй, нийгмийн талаар мэдрэмжтэй, аливаа асуудлыг олон талаас нь тунгаан бодох, орон нутаг, бүс, дэлхий нийтийн асуудлаар мэдлэг, мэдээлэлтэй иргэдийг хүмүүжүүлэх;
- Хүүхэд, багачуудад Сингапурчуудын үндэсний онцлогийг судлах, танин мэдэх, ойр дотнынхондоо тусалж дэмжих, өөрсдийн амьдарч буй орчин, цаашлаад нийгмийн сайн сайхан байдалд хувь нэмрээ оруулах замаар цаашдын зорилгоо тодорхойлоход нь туслах зэрэг болно.

Сургуулийн танхимаас гадуур хамрагдах хөтөлбөр

Эрүүл чийрэг, спортлог, эх оронч, хүнлэг, тусч, чадвартай иргэн бэлтгэх зорилго бүхий Сургуулийн танхимаас гадуур олгох, заавал хамрагдах боловсролын хөтөлбөр (Co-curricular activities)⁸³ - үүдийг тухайн сургуулийн хүүхдүүдийн хүсэл, сонирхлыг харгалзан клуб, дугуйлан хэлбэрээр зохион байгуулж, хэрэгжүүлдэг байна. Үүнд, урлаг, спорт, дүрслэх урлагийн дугуйлангууд болон дүрэмт хувцас бүхий холбоод (uniformed groups) багтдаг байна. Ерөнхий боловсролын дунд сургуулиудын хэмжээнд 9 томоохон дүрэмт хувцас бүхий холбоод үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал, Хөвгүүдийн бүлэг, Охидын бүлэг, Охидын хөтөч, Үндэсний цэргийн бэлтгэл сургууль, Үндэсний цагдаагийн бэлтгэл сургууль, Иргэний батлан хамгаалах бэлтгэл сургууль, Өсвөрийн Улаан загалмай, Скаутууд болон Гэгээн Жоны нэрэмжит Түргэн тусламжийн баг зэрэг болно. Эрүүл мэндийн яамны харьяа Эрүүл мэндийг дэмжих зөвлөл (Health Promotion Board)-өөс хүүхдүүдийн эрүүл амьдралын хэв маягийг дэмжих зорилгоор

⁸² <https://www.moe.gov.sg/education-in-sg/our-programmes/national-education>

⁸³ <https://www.nlb.gov.sg/main/article-detail?cmsuuid=fa092bc5-6339-4c60-beb2-b6355d6027cc>

Эрүүл мэндийг дэмжих клуб (Health Promotion Club)-ыг Канберра дунд сургууль дээр санаачлан, эхлүүлсэн байна.

Сурагчид өөрсдийн сонирхлоор сонгон, нэг буюу түүнээс дээш заавал хамрагдах шаардлагатай эдгээр хөтөлбөрүүдийг 1995 оноос урамшууллын оноо (bonus)-той болгосон бөгөөд Өсвөрийн коллеж (Junior college) болон Политехникийн коллежид элсэн суралцахад тус оноог харгалзан үздэг байна. Түүнчлэн 2003 оноос Сингапур Улсын Үндэсний Их Сургууль (National University of Singapore) болон Нанянг Технологийн Их Сургууль нь тус тус Өсвөрийн коллеж болон Политехникийн коллежид суралцагсад, армид алба хаагчдын дээрх үнэлгээг элсэлтийн шалгууртаа харгалзан үзэхээр шийдвэрлэсэн байна.

Сурагчдын бүх талын хөгжилд тус хөтөлбөрийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, сурагчдын тасралтгүй оролцоо, хүчин чармайлтыг үнэлэн 2003 оноос тус хөтөлбөрийг үнэлгээтэй болгосон байна. Дунд сургуулийн сурагчид манлайлал, сайжруулалт, амжилт, оролцоо, хэрэглээ гэсэн 5 чиглэлээр дүгнүүлэх болсон байна. Ингэснээр сурагчид анги хоорондын, сургуулийн доторх, түүнчлэн сургуулиас гадуур олон төрлийн арга хэмжээнд идэвхтэй хамрагдах болжээ.

Академик хичээлийн хажуугаар олгох эдгээр сургалт хүмүүжлийн хөтөлбөрүүдийг заах дасгалжуулагч багш нарыг 2015 оны 01 дүгээр сараас Боловсролын яаман дээр бүртгэх болсон. Ингэснээр сургуулиуд тодорхой сургалтыг заах, шаардлагатай ур чадвар бүхий багш нарын мэдээллийг олж авах албан ёсны эх сурвалжтай болсон байна.

“Ёс зүй, иргэний боловсрол” хөтөлбөр

“Иргэний болон ёс суртахууны боловсрол”, “Үндэсний боловсрол” болон Сургуулийн танхимаас гадуур олгох боловсролын хөтөлбөрүүдийг нэгтгэн, хувьсан өөрчлөгдөж буй дэлхийд залуу Сингапурчуудыг бэлтгэх зорилго бүхий “Ёс зүй, иргэний боловсрол” цогц хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан байна. Ерөнхий боловсролын сургуулийн бага болон дунд ангид 2014 оноос, ахлах ангийн сурагчдад 2016 оноос тус тус зааж эхэлжээ.

“Ёс зүй, иргэний боловсрол” сургалтын хөтөлбөр нь “Үнэт зүйлийг хэвшүүлэх” (Values in Action) буюу “Нийгэм дэх хувь хүний оролцоо хөтөлбөр” (Community Involvement Programme)⁸⁴ болон “Үнэт зүйлийг төлөвшүүлэх” (Values in Practice) зэрэг дэд хөтөлбөрүүдийг багтаадаг байна.

⁸⁴ <https://www.nlb.gov.sg/main/article-detail?cmsuuid=c78526c6-decf-4b79-b4ca-421739464884>

“Үнэт зүйлийг хэвшүүлэх” - “Нийгэм дэх хувь хүний оролцоо” хөтөлбөрийг нийгмийн тайван амгалан, нэгдмэл байдал, үүнд иргэн хүний хүлээх үүрэг хариуцлагыг сурагчдад төлөвшүүлэх зорилготой эхлүүлжээ. Хүүхэд багачуудад тухайн газар нутаг, нийгэм, улс орныхоо нэг хэсэг болох, түүнчлэн үүрэг, хариуцлагатай байх зэргийг сургуулийн болон харьяа нутаг дэвсгэрийн нийтийг хамарсан, сайн үйлсийн аянд идэвхтэй оролцуулах, туршлага суулгах арга барилаар олгодог байна. Тус хөтөлбөрт Ерөнхий боловсролын сургуулийн бүх ангийн сурагчид жил бүр 6-аас доошгүй цаг заавал хамрагдах ёстой бөгөөд бага, дунд сургуульд 10 жил суралцахад доод тал нь 60 цагийн сайн үйлсийн аянд хамрагдсан байдаг байна.

Насны бүлгээс хамаарч хүүхдүүд өөр ажлуудад хамрагдах бөгөөд бага ангийн хүүхдүүд бүлэг болон нэг нэгэндээ хичээл заах, мод, цэцэг тарих, ургуулах, сургуулийн орчинд хөнгөн ажил гүйцэтгэх, гар урлал хийж, түүнийгээ борлуулан хуримтлалын санд хандивладаг байна. Дунд ангийн хүүхдүүд нийтийн номын сан, хүүхэд болон ахмад настны асрамжийн газрууд, харилцан туслалцах бүлгүүдэд туслах ажил хийх, цэцэрлэгт хүрээлэн, далайн эргийн наран шарлагын газар зэрэг нийтийн эзэмшлийн газруудыг цэвэрлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэдэг байна. Ахлах ангийн сурагчид бага, дунд ангийн сурагчдад бүлгээр ажиллах, анги танхимаас гадуурх үйл ажиллагаанд нь туслах, удирдан чиглүүлэх, манлайлах зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэдэг байна. 2005 оноос ахлах ангийн сурагчдын сайн үйлсийн аянд заавал хамрагдах цагийг нэмэгдүүлсэн байна. Сурагчид сайн үйлсийн аянд хэрхэн хамрагдсан талаарх үйл явц, үнэлгээний тэмдэглэлийг хөтөлдөг байна.

“Үнэт зүйлийг төлөвшүүлэх”⁸⁵ бага ангийн хүүхдүүдэд зориулсан цахим хөтөлбөрийг 2016 оноос эхлэн хэрэгжүүлсэн бөгөөд хүүхдүүдэд багаас нь эргэн тойрны хүмүүстээ халамж, анхаарал тавих, туслах, талархлаа илэрхийлж байх, хүндлэх, нэгдмэл байх, хариуцлагатай байх зэрэг хүний үнэт зан чанаруудыг ойлгуулах, төлөвшүүлэх зорилготой. Тус хөтөлбөрт Боловсролын яамны зөвшөөрөл бүхий цахим хичээл, тоглоом, хүүхэлдэйн кино, хэвлэн авах боломжтой ном, товхимлыг ашигладаг байна. Эдгээр сургалтын хэрэглэгдэхүүнүүдийг Англи, Мандарин, Малай, Тамил гэсэн 4 хэл дээр авч, ашиглах боломжтой.

Бага ангийн хүүхдүүдэд хүний эрхэм зан чанарын талаар бяцхан түүхээр дамжуулан ойлгуулах, “хэрэв тэгвэл” гэсэн хувилбаруудаар хэлэлцүүлэх, үлгэр дуурайл авах хүний талаар ярилцах, хүрээлэн буй орчиндоо сайн үйлс хийж байх зэрэг ёс суртахууны хүмүүжлийг олгох, хүний үнэт зан чанарыг багаас нь төлөвшүүлэх тус хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

⁸⁵ <https://values-in-practice.com/>

Сингапур Улсын иргэншлийн хөтөлбөр⁸⁶

Соёл, олон нийт, залуучуудын яам (Ministry of Culture, Community and Youth), Үндэсний нэгдмэл байдлын зөвлөл (National Integration Council), Ард түмний нийгэмлэг (People's Association) болон Сингапур Улсын цагаачлал, шалган нэвтрүүлэх газар хамтран Сингапур Улсад амьдрахаар цагаачлан ирсэн иргэдэд зориулан Сингапур Улсын түүх, соёл, үнэт зүйл, иргэн хүний хүлээх үүрэг, хариуцлага зэрэг иргэн бүрийн мэдэж байвал зохих мэдлэг, мэдээллийг багтаасан 2 сарын хугацаатай, заавал хамрагдах Сингапур Улсын иргэншлийн хөтөлбөр (Singapore Citizenship Journey) сургалтыг жил бүр зохион байгуулдаг байна. Сургалтаар Сингапур Улсад суурьшихаар зорин ирсэн хүмүүст тус улсын түүх, хөгжлийн гол үе шатууд, Сингапурчуудын нийгмийн хэм хэмжээ, үнэт зүйлсийн талаарх мэдлэгийг гүнзгийрүүлэн олгохын сацуу тухайн орон нутгийнхаа аж байдалтай танилцах, дасан зохицоход нь тусалдаг байна. Сургалт нь цахим сургалтын модулиуд, туршлага судлах хөтөлбөр, олон нийттэй харилцах гэсэн хэсгүүдээс бүрддэг. Сургалтын төгсгөлд албан ёсны арга хэмжээ зохион байгуулан, сургалтад хамрагдагсдыг Сингапур Улсын иргэн болсныг албан ёсоор мэдэгдэн, Иргэний бүртгэлийн үнэмлэх (National Registration Identity Card)-ийг гардуулдаг байна.

Жилд ойролцоогоор 13.000-16.000 цагаач иргэд энэхүү хөтөлбөрт хамрагддаг бөгөөд 65% гаруй нь 14-65 насны иргэд, эдгээрээс 60% гаруй нь Зүүн өмнөд Азийн орнуудаас цагаачлан ирэгсэд байна.

2020 онд Сингапур Улсын иргэдийн олон талын төлөөлөл бүхий ажлын хэсгийг байгуулан, юу биднийг Сингапур үндэстэн болгодог, Сингапур улсын иргэн болохоор зорин ирж буй хүмүүс бидний бүтээсэн нийгмийн талаар юуг мэдвэл зохих вэ гэсэн нэгдмэл ойлголтод хүрэхийн тулд 7 сар гаруй хугацаанд судлан, хэлэлцэж, тус хөтөлбөрийн агуулгыг шинэчлэн “Сингапурт тавтай морил” гарын авлагыг боловсруулсан байна. Гарын авлагад шинэ иргэдэд зориулсан анхан шатны буюу амьдрах орон байр, ажил, сургууль, эрүүл мэнд, нийгмийн халамж, банк санхүүгийн үйлчилгээнээс эхлээд Сингапур хүмүүсийн амьдралын хэв маяг, Сингапур улсын түүх, үнэт зүйл, үндэсний бэлгэ тэмдэг, засаг захиргааны зохион байгуулалт, иргэн хүний хүлээх үүрэг буюу улс орноо батлан хамгаалах, олон үндэстний ёс заншлыг хүндэтгэх, нийгэмд хувь нэмрээ оруулах, сонгуульд саналаа өгөх, түүнчлэн Сингапур Улсын ирээдүйн зорилго, урт хугацааны төлөвлөлтийн талаар болон яаралтай тусламжийн газруудтай хэрхэн холбогдох зэрэг зайлшгүй мэдвэл зохих мэдээллийг товч, тодорхой байдлаар багтаасан байна.⁸⁷

⁸⁶ <https://www.sgjourney.gov.sg/>

⁸⁷ <https://www.sgjourney.gov.sg/pdfs/welcome-to-singapore/>

2.2. БҮГД НАЙРАМДАХ ЭСТОНИ УЛС

Эстони Улсад үндэсний хэмжээнд нийгмийг соён гэгээрүүлэх гэдэг нь боловсролын бүх түвшинд иргэний боловсролыг олгох, нийгмийн ёс зүйг төлөвшүүлэх, үндэсний үнэт зүйлийг таниулан сургах, бие хүнийг төлөвшүүлэх, насан туршийн боловсрол олгох үйл явц юм. Үүнийг сургалтын үндэсний хөтөлбөрүүд, нийгмийн болон иргэний боловсролын үндэсний хөтөлбөр, насан туршийн боловсролын стратеги, боловсролын стратегийн хүрээнд явуулж байна.

Иргэний боловсрол ба нөхцөл байдал⁸⁸

Тус улс 1991 онд ЗХУ задарсны дараа тусгаар тогтнолоо сэргээж, тоталитар дэглэмээс ардчилсан тогтолцоо руу шилжих эрс шинэчлэлийг эхлүүлсэн байдаг.

Энэ нь тухайн улсад баримталж ирсэн үнэт зүйлийн тогтолцоо задарч, ард иргэд үнэт зүйлийн баримжаагаа алдсантай холбоотойгоор үндэсний уламжлалт үнэт зүйлсээ олон ургальч, ардчилсан тогтолцоонд нийцүүлэн сэргээж боловсруулах, хөгжүүлэх, улмаар түүнийг олон нийтэд таниулан сургах цогц ажлыг хийх шаардлагатай болсон.

Дээрх нөхцөл байдал нь тухайн үеийн социалист нийгмийн тогтолцооноос ардчилсан нийгмийн тогтолцоо руу шилжиж байсан бүх улс оронд тулгамдсан нийтлэг сорилт, асуудал байсан юм.

Энэ шинэчлэлийн хүрээнд нэн тэргүүнд боловсролын шинэчлэлийг явуулж, үндэсний сургалтын хөтөлбөр, нийгмийн болон иргэний боловсролын хөтөлбөрийг боловсруулсан нь тус улсын зүгээс дээрх сорилтыг даван туулах эхний чухал алхам байжээ. Энэ нь Эстони Улсын орчин үеийн үндэсний боловсролын бодлого, үзэл санааны суурь үндсийг тавьсан гэж үздэг.

Зөвлөлт маягийн “коммунист интернационализмыг глобалчлах” чиг баримжаатай иргэний боловсрол, түүх, соёл, хэлний сургалтын хөтөлбөрийг орчин үеийн үзэл санаа болон эстони үндэсний онцлогт нийцүүлэн боловсруулж 1996 оноос бүх шатны боловсролын байгууллагад хэрэгжүүлж эхэлсэн. Тухайн цаг үед Эстонид орос хэл, эстони хэлний асуудлаас болж соёлын ялгаа ихээхэн үүсдэг байв.

Сургалтын үндэсний хөтөлбөр нь хүүхэд, залууст нийгмийн үнэт зүйлс, үндэсний хэл, соёл, түүх, иргэний боловсролын мэдлэг олгох, соёлын ялгаатай байдлыг арилгах, соён гэгээрүүлэхэд чухал ач холбогдолтой

⁸⁸ https://link.springer.com/content/pdf/10.1007/978-3-030-71102-3_7.pdf

байжээ. Орон нутгийн сонгуульд санал өгөх иргэдийн насыг 16 болгосон нь хүүхдүүдэд, ялангуяа энэ насны хүүхдүүд суралцдаг 9 дүгээр ангид Иргэний боловсролын хичээлийг нарийвчлан заах, мөн орос хэлтэй хүүхэд, залуусыг эстони хэл соёлд сургах нэг үндсэн шаардлага нөхцөл болсон. Үүнд ёс зүйг иргэний боловсролын агуулгад хамааруулж байв. Уг хөтөлбөрийн үндсэн хэсэгт боловсролын үндсэн үнэ цэн болон сургууль боловсролын шатлалыг, харин дэд хэсэгт нь албан ёсоор заавал судлах хичээл тус бүрийн агуулга хөтөлбөрийг тодорхойлсон байна.

Бага дунд шатны иргэний боловсролын гол зорилго нь нийгмийн анхан шатны мэдлэг, нийгмийн үндсэн ур чадварыг нийгэмд олгох явдал байв. Дунд шатны иргэний боловсролын хөтөлбөр нь улс төрийн институци, түүний үндсэн хуулийн дэг журмын талаарх мэдлэгийг хангахад чиглэгдсэн байдаг бол бүрэн дунд түвшинд эдийн засаг, нийгэм, улс төрийн үйл явцын нь хувьд ертөнцийг харилцан уялдаатай бүхэл бүтэн цогц байдлаар ойлгохыг зорьсон байдаг.

Сургалтын үндэсний хөтөлбөр, нийгмийн болон иргэний боловсролын үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээр тус улсын үзэл санааны хандлагад асар их өөрчлөлт орсон ч энэ нь боловсролын байгууллагын хичээл, сургалтад суурилсан уламжлалт бүтцийг хадгалсан хэвээр байгаа нь дэвшүүлж буй үндэсний хэмжээний зорилгыг хэрэгжүүлэхэд хангалтгүй, хязгаарлагдмал шинжтэй байна гэж үзсэн тул “иргэний боловсрол”-ыг дунд сургуулийн дунд, ахлах ангиудад албан ёсоор заавал судлах хичээлд оруулан тодорхойлж, 1998 онд Насан туршийн боловсролын стратегийг боловсруулан, ёс зүй, иргэний боловсролыг өргөн хүрээнд хүртээмжтэй олгох нөхцөлийг бүрдүүлжээ. Улмаар Насан туршийн боловсролын стратеги нь 2020 онд хэрэгжиж дууссан бөгөөд одоо түүний хэрэгжилтийн үнэлгээнд суурилан боловсруулсан “Боловсролын стратеги 2021-2035”-ийг⁸⁹ хэрэгжүүлж байна. Энэ нь бүх түвшний боловсролын хөгжлийг тодорхойлохоос гадна ардчилсан, ёс зүйтэй, Эстони Улсын иргэнийг төлөвшүүлэх бодлогыг агуулсан өргөн хүрээтэй шинэ зорилтийг дэвшүүлсэн байна.⁹⁰

Мөн 2001 онд Тарту их сургуулийн Философийн факультетийн бүрэлдэхүүнд “Ёс зүйн төв”-ийг салбар хоорондын уялдаа холбоог судлах зорилгоор байгуулж, улмаар 2009 онд концерцум болгон өргөжүүлсэн. Тус төв нь эхлээд их дээд сургуулиудын нийгмийн болон иргэний боловсрол, ёс зүйн хичээлүүдийн агуулгыг тодорхойлох, энэ чиглэлээр лекц, гарын авлагыг бэлтгэх зэргээр хязгаарлагдмал хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байсан бол 2009 оноос олон нийтэд зориулсан танин мэдэхүйн үйл ажиллагаа, сургалт, салбар мэргэжлийн ёс зүйн дүрмийг боловсруулах, судалгаа, дүн шинжилгээ хийх, ёс зүйн хичээл, сургалтын багш нарыг бэлтгэх ажлыг тус тус явуулдаг болсон.

⁸⁹ https://www.educationestonia.org/wp-content/uploads/2022/12/haridusvaldkonna_arengukava_2035_kinnitaud_vv_eng_0-1.pdf

⁹⁰ <https://www.educationestonia.org/innovation/>

Нийгмийн болон иргэний боловсролын үндэсний хөтөлбөрийн өөрчлөлт, шинэчлэлт⁹¹

Эстоний хамгийн анхны сургалтын үндэсний хөтөлбөрт (1996) “Иргэний боловсрол” хичээлээр заах маш өргөн хүрээтэй сэдвүүдийн жагсаалтыг тусгасан байдаг. Үүнд логик, үндсэн хууль, ардчиллын зарчмууд, нийгмийн бүтэц, эдийн засаг багтсан байна. Энэ нь тогтолцооны өөрчлөлт, шилжилтийн үед иргэний боловсролын олон зорилго, зорилтыг бүрэн хангах үүднээс философи, хууль, эдийн засаг, иргэний мэдлэг боловсролыг нэгтгэн хослуулахыг зорьсон. Гэсэн хэдий ч багш нарт зориулсан заах арга зүйн тодорхой гарын авлага байсангүй. Тиймээс багш нарын ном, сурах бичгийн дутагдалтай байдлыг арилгах үүднээс 1996 оны үндэсний хөтөлбөрийг эш үндэс болгосон хамгийн анхны сурах бичгийг 1997 онд хэвлүүлжээ.

Энэхүү сургалтын үндэсний хөтөлбөрийг хичээл хоорондын уялдаа холбоог Иргэний боловсролд чиглүүлэх, ардчилсан ёсонд суурилсан сургуулийн ач холбогдлыг чухалчлах зорилгоор 2002 онд шинэчлэн боловсруулжээ.

Эцэг эхчүүд, сурагч оюутнууд, багш нарын зүгээс хэтэрхий олон төрлийн хичээлийн улмаас сурагчид хэт их ачаалалтай байна гэсэн санал гомдлыг илэрхийлэх болсон, мөн мэргэжлийн байгууллагуудын зүгээс хичээл хоорондын уялдаа холбоо муу, “бодит амьдрал”-аас хэтэрхий хол, хөндий байна гэх шүүмжлэлүүд гарах болсонтой холбоотойгоор “Үндэсний хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулах асуудал 2005-2006 оны үед дахин хөндөгдсөн байдаг. Эдгээр шүүмжлэл нь Нийгмийн болон иргэний боловсролын хөтөлбөрт мөн хамааралтай байв. Гэсэн ч тухайн үеийн шинэчлэх оролдлогыг дорвитой сайн өөрчлөлт болгохооргүй байна гэж үзжээ. Учир нь хөтөлбөрийг өөрчлөх хуулийн төсөлд нийгмийн ухааны хичээлүүдийг сэтгэл судлал, эрүүл мэндийн боловсролтой механикаар холбон нэгтгэсэн, хичээлийн зарим чухал сэдвийг учир үндэслэл муутайгаар хассан гэх зэрэг дутагдал их байв.

Харин 2011 оны хөтөлбөрийн шинэчлэлээр дунд сургуулийн дунд болон ахлах ангиудад заах хичээлийн хөтөлбөрийг тодорхой ялган боловсруулах гэх зэргээр сургалтын хэт их ачааллын асуудлыг шийдвэрлэхийг оролдсон. Гол үндэслэл нь дунд ангийн хүүхдэд зориулсан иргэний боловсролын хичээлийн агуулга нь нийгмийн бодит асуудлуудтай нягт холбогдсон, өсвөр үеийнхнийг идэвхтэй иргэн болж төлөвшин хүмүүжихэд нь бэлтгэдэг байх ёстой гэж үзэж байв. 2009 оны ICCS (International Civic and Citizenship Education Study-Олон улсын нийгмийн болон иргэний боловсрол судлал)-ийн нөлөөгөөр “нийгэм судлал”-ын хичээлийн нэрийг “иргэний боловсрол” болгон өөрчилжээ.

⁹¹ https://link.springer.com/content/pdf/10.1007/978-3-030-71102-3_7.pdf

Улмаар нийгмийн болон иргэний ур чадвар хэмээх хэт ерөнхий ур чадварын сургалтыг практик амьдралын ач холбогдол бүхий агуулгаар солих үүднээс 2014 оны хөтөлбөр шинэчлэлтийг дахин хийсэн байна. Үүнд иргэний ур чадварыг Европын боловсрол, сургалтаар олгох гол түлхүүр ур чадварууд гэх зэргээр Европын Холбооны бодлогын бичиг баримтуудад зааснаар тодорхойлжээ. Ийнхүү урьд өмнөх үндэстэн төвтэй хандлага нь зөөлөрч, дэлхий нийтийн ардчиллын болон Европын үнэ цэнийг эрхэмлэх хандлага нь нэлээд өссөн байна.

2014 онд шинэчлэн боловсруулсан хөтөлбөрт сургалтын үр дүнг гурван түвшинд тодорхойлсон. Үүнд: Ерөнхий ур чадвар, нийгмийн ухааны салбар тус бүрийн ур чадварууд, иргэний боловсролын сэдэв тус бүрээс эзэмших ур чадварууд багтжээ.

Ерөнхий түвшинд, суралцагчийн эзэмшвэл зохих нийгмийн болон иргэний ур чадварыг тодорхойлохдоо: “өөрийгөө улс нийгмийнхээ ардчилсан хөгжлийг дэмждэг, мэдээлэл сайтай, үүрэг хариуцлагатай иргэний ёсоор аж төрөгч хүмүүн болгон төлөвшүүлэх ур чадвартай; нийгмийн үнэ цэн болон хэм хэмжээг мэддэг бөгөөд даган мөрддөг, нийгмийн аливаа өөр орчны дүрэм журам, нийгэм, шашин, үндэстэн угсаатаны олон янз байдлыг хүндэтгэдэг; янз бүрийн нөхцөл байдалд бусад хүмүүстай хамтран ажилладаг; хүмүүсийн хоорондын ялгааг хүлээн зөвшөөрч, ойлгодог байх” гэжээ.

Нийгэм судлалын ухааны салбарт, сургалт болон сурах үйл ажиллагааны зорилго нь “нийгмийн аливаа өөрчлөлтийн шалтгаан ба үр дагаврыг ойлгох чадвар; хүний эрх ба ардчиллын талаар мэдлэгтэй байх, тэдгээрийг хүндэтгэдэг байх; иргэний эрх, үүргийн талаар мэдлэгтэй, үүний дагуу өөрийн үйлдлээ хянан зохицуулах чадвартай байх; соёлын олон янз байдлыг хүлээн зөвшөөрөх чадвартай байх; биеэ авч явах нийтийн ёс, журмыг даган мөрдөх чадвартай байх; нутаг орон, үндэстэн, төр ба дэлхий нийтээрээ хөгжих явдлыг эрхэмлэдэг байх; өөрийн гэсэн үзэл бодолтой, идэвхтэй бөгөөд хариуцлагатай иргэн байх; нийгмийн талаар судлан үзэхдээ судалгаа шинжилгээний энгийн арга, аргачлалуудыг ашиглах мэдлэг, чадвартай байх; хүрээлэн буй байгаль дэлхийгээ эрхэмлэдэг байх зэрэг нийгмийн ур чадваруудыг суралцагчдын насанд нь тохируулан эзэмшүүлэх”-д оршино гэжээ.

Иргэний боловсролын хичээлийг судалсны үр дүнд сурагчид дараах чадварыг эзэмшинэ. Үүнд: “нийгэмдээ идэвхтэй амьдардаг, хариуцлагатай шийдвэр гаргадаг иргэн болоход шаардлагатай мэдлэг, ур чадвар, үнэ цэн, хандлага зэрэг нийгэмд амьдрах ёс, журмыг танин мэдэж, эзэмшинэ”. Иргэний боловсролын хичээлийг 6 дугаар ангид жилд 35 цаг, 8, 9 дүгээр ангиудад жилд 70 цаг зааж байна.

Ихэнх сургуулиудад иргэний боловсрол хичээлийг 15-16 насны хүүхдүүд суралцдаг 9 дүгээр ангид нь голчлон зааж байна. Учир нь 9 дүгээр анги бол заавал эзэмших боловсрол, сургалтын хамгийн сүүлчийн жил байдаг байна.

Үндэсний өв, соёл, иргэний боловсролыг сургалтын хөтөлбөрт тусгасан байдал⁹²

Суурь сургуулийн үндэсний хөтөлбөр (*National curriculum for basic schools*)-т үндэсний соёлын өв уламжлал, ёс суртахуун, иргэний боловсролтой холбоотой асуудлыг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

2 дугаар зүйлд суурь боловсролын үндсэн үнэт зүйлсийг тодорхойлсон ба 2.3-т Сургалтын хөтөлбөрт чухал гэж тооцсон үнэт зүйлс нь Эстоний Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Хүүхдийн эрхийн тухай конвенц болон Европын холбооны суурь баримт бичгүүдэд заасан ёс зүйн зарчмуудаас үүдэлтэй байна.

Хувь хүний нийтлэг үнэт зүйлс (үнэнч, энэрэнгүй байх, шударга ёс, өөрийгөө болон бусдыг хүндэтгэх) болон нийгмийн үнэт зүйлс (эрх чөлөө, ардчилал, эх хэл, соёлыг хүндэтгэх, эх оронч үзэл, соёлын ялгаатай байдлыг хүндэтгэх, байгаль орчны тогтвортой байдал, хууль дээдлэх ёс, үүрэг хариуцлага болон жендерийн эрх тэгш байдал) нь боловсролын үндсэн үнэт зүйлс байна. Хөтөлбөрийн 2.4-т Эстоний соёлын уламжлал, Европын нийтлэг үнэт зүйлс, дэлхийн соёл, шинжлэх ухааны ололт амжилтыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр өсвөр үе, хүүхэд залуучуудын нийгэмших үйл ажиллагаа явагдана. Чанартай суурь боловсрол эзэмшсэн хүмүүс нийгэмд дасан зохицох чадвартай байж, Эстоний нийгэм, соёл, эдийн засаг, экологийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах болно гэж тус тус заасан байна.

3-р зүйлд Суурь сургуулийн зорилтуудыг тодорхойлсон ба 3.7-д Эстоний сургуулиуд нь Эстони үндэстэн, хэл, соёлыг хамгаалж, хөгжүүлэх үүргийг хүлээсэн учир суурь сургуульд эстони хэлийг судлахад онцгой анхаарна гэж заасан.

4-р зүйлд Сурагчдад ямар чадамж эзэмшүүлэх талаар заасан ба 4.3.1-д соёл, үнэт зүйлсийг үнэлэх чадамж нь хүмүүс хоорондын харилцаа, үйл ажиллагааг нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны хэм хэмжээний хүрээнд/үүднээс үнэлэх; бусад хүмүүс, нийгэм, байгаль орчин, өөрийн орны болон бусад улсын соёлын өвтэй холбоотой харилцааг мэдэрч, үнэлэх; гоо зүйн мэдрэмжтэй болж, үнэлэх; хүний болон нийгмийн ерөнхий

⁹² Гадаадын зарим орны бага, дунд боловсролын тогтолцоо ба үндэсний өв соёлыг сургалтын агуулга, хөтөлбөрт тусгасан байдлын талаарх харьцуулсан судалгаа (СТ-18/210), УИХТГ-ын ПССХ.

үнэт зүйлсийг үнэлэх, хүн төрөлхтөн, соёл, байгалийн олон янз байдлыг үнэлэх, өөрийн үнэт зүйлийг тодорхойлох зэрэг болно.

11-р зүйлд сургалтын 3 дугаар шатанд (7-9-р анги) эзэмших чадваруудыг тодорхойлсон ба 11.11-д өөрийгөө бүтээлч байдлаар илэрхийлж, урлаг, соёлын өвийг хүндэтгэх гэж заасан.

14-р зүйлд хичээл хоорондын уялдаа холбоог тодорхойлсон ба 14.4-т соёлын ижилсэл нь сурагчийг соёлын талаарх мэдлэгтэй болгож, хүний үзэл бодол, зан байдалд үзүүлэх соёлын нөлөөг ойлгодог, соёлын түүхэн өөрчлөлтүүдийг мэддэг, соёлын олон янз байдал, хүний амьдралын хэв маяг дахь соёл, зан заншлын нөлөөг ойлгож, үндэсний соёл, соёлын олон янз байдлыг хүндэтгэж, соёлын тэвчээртэй байж хамтран ажиллахад бэлэн байхад чиглэгдэнэ гэж тодорхойлсон байна.

Дээрхээс үзвэл, суралцагчдыг багаас нь нийгмийн үнэт зүйл, үндэсний өв соёл, ёс зүй хүмүүжил, иргэний боловсролтой иргэн болгон бэлтгэхэд анхаарч байна.

Ёс зүйн төвийн үйл ажиллагаа

Ёс зүйн төв нь анх 2001 онд Тарту их сургуулийн Философийн факультетийн бүрэлдэхүүнд салбар хоорондын ухаан судлалын нэгж хэлбэрээр байгуулагдаж, улмаар 2009 оноос концерцумын хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах болжээ.

Төвийн үйл ажиллагаанд оролцогч факультетууд нь: урлаг ба хүмүүнлэгийн факультет, нийгмийн шинжлэх ухааны факультет, анагаах ухааны факультет, шинжлэх ухаан, технологийн факультет.

Төвийн удирдах дээд байгууллага нь дээр дурдсан факультетууд болон оюутны төлөөллөөс бүрдсэн гишүүд бүхий удирдах зөвлөл байна. Тус төв нь бас олон улсын хандивлагчдын зөвлөлтэй.

Төвийн зорилго нь:

- Шинжлэх ухаан, нийгэм, эрдэм шинжилгээний ажилтай холбогдох ёс зүйн асуудлуудын талаар салбар хоорондоо судалгааг зохион байгуулах;
- Олон нийтийн лекц яриа, уулзалт, семинар, хэлэлцүүлэг зохион байгуулах замаар Эстонийн нийгэм дэх хэм хэмжээ, үнэ цэн, шударга ёсны асуудлуудыг гүнзгийрүүлэн судлах;
- Тарту их сургуулийн ёс зүйн сургалтыг удирдан сайжруулж, ёс зүйн чиглэлийн ном зохиол, судалгааны бүтээл туурвих, эмхэтгэх, хэвлэн нийтлүүлэх;

Тус төв нь олон нийтэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг явуулна. Төвийн нэг гол зорилго нь нийгмийн ёс зүйн ухамсарыг дээшлүүлэх, үнэ цэн болон хэм хэмжээний талаарх яриа хэлэцүүлэгт олон нийтийг өргөнөөр оролцуулах явдал байдаг. Төв нь эрдэм шинжилгээний хурал, семинар зохион байгуулах замаар нийгмийн ач холбогдол бүхий олон чухал асуудлыг олон нийтийн хүрээнд хөндөн гаргаж тавьдаг. Тухайлбал, Ёс зүйн төв нь жил бүрийн 12 дугаар сард “Нийтлэг үнэ цэнийн эрэлд” нэрт цуврал эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулдаг байна. Энэ хурлаар өөр бусад улс орны үнэ цэнийн боловсролын туршлагын талаар судлан үздэг ажээ.

Олон нийтэд чиглэсэн үндсэн үйл ажиллагаа:

- “Эстонийн нийгэмд үнэ цэнийг хөгжүүлэх нь, 2009-2013” үндэсний хөтөлбөрийг Эстони Улсын боловсрол, эрдэм шинжилгээний яамтай хамтран хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь хоёр удаа шинэчлэгдсэн ба одоогийнх нь 2021-2026 оны хооронд хэрэгжихээр байна.
- Ёс зүйн төвийн санал санаачилга, ЮНЕСКО, Боловсрол, эрдэм шинжилгээний яам, Нийгмийн асуудал хариуцсан яам, Тарту их сургуулийн дэмжлэгтэйгээр интернет сүлжээнд Ethicsweb – “Ёс зүйн цахим хуудас” нээн ажиллуулж байна. Энэ нь ёс зүйн дата өгөгдлийн баазын үүргийг гүйцэтгэдэг. Ёс зүйн энэ цахим хуудсаараа ёс зүйтэй холбогдох ном хэвлэл, хууль журам, сургалт, кэйс судалгаа, ёс зүйн кодууд, ёс зүйн хороод, ёс зүйн сургалт, судалгаа эрхэлдэг байгууллагуудын мэдээллийг цуглуулах боломжтой. Харин форум хэлэлцүүлгээр хүмүүс ёс зүйн асуудал, үнэ цэн, үнэт зүйлийн асуудлыг хөндөн ярилцдаг.
- Ёс зүйн төв нь мөн хууль тогтоох үйл явцад ёс зүйн дүн шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэнэ. Энэ төрлийн хамгийн өндөр төсөвтэй судалгаа нь Эстони Улсын Нийгмийн асуудал хариуцсан яамны захиалгаар хийсэн “Эрүүл мэндийн цахим түүх” төсөл байжээ.
- Төв нь Эстонийн Био-ёсзүйн зөвлөл ([Estonian Council on Bioethics](#)), Нийгмийн асуудал хариуцсан яамны дэргэдэх Эрүүл мэндийн мэдээллийн системийн ёс зүйн хороо, Тарту их сургуулийн Хүний асуудлын судалгааны хороо, мөн Тарту их сургуулийн Эмнэлгийн ёс зүйн хороо зэрэг байгууллагуудтай байнгын хамтын ажиллагаатай ажилладаг.
- Төв нь бусад их сургууль, байгууллагуудтай хамтран ёс зүйн судалгаа шинжилгээний ажлын чиглэлээр төрөл бүрийн сургалт, семинарийг зохион байгуулдаг.

Тус төвийн харилцагч нар нь олон нийтийн телевиз, радиогоор яриа, ярилцлагыг тогтмол өгч байна. Мөн төв нь олон нийтэд зориулсан үнэ

цэнэ, үнэт зүйлсийн тухай эрдэм шинжилгээний хурлуудыг зохион байгуулж, радиогоор нэвтрүүлэхээс гадна олон тооны ном зохиолуудыг уншигч олны гар дээр хүргээд байна.

2.3. ЯПОН УЛС

Япон Улсын хувьд улсаа хөгжүүлнэ гэвэл нийгмийн ёс зүй, хувь хүний ёс суртахууныг сайн дэмжих хэрэгтэй гэж үздэг ард түмэн билээ. Японы хөгжлийн нэг тулгуур болох самурайн ёс зүй, ёс суртахууны системийг дэлхий дахинд Нитобэ Иназо 1900 онд “Бүшидо: Япон Улсын Амин Сүнс” (Bushido: The Soul of Japan) гэх номоороо танилцуулж байжээ.

Япон хүн бүрт байх ёстой 8 цөм ёс суртахуун:

- Зөв байх, зөвийг эрхэмлэх (Righteousness)
- Баатар байх эсвэл зоригтой байх (Heroic Courage)
- Нигүүлсэнгүй байх (Benevolence, Compassion)
- Өөртөө болон өөр хоорондоо хүндэтгэлтэй байх (Respect)
- Зарчмыг баримталдаг, жанжин шугамаасаа хазайхгүй, амласнаа биелүүлдэг байх (Integrity)
- Үндэсний соёл, үнэт зүйлээр бахархах, нэр төрийг нь өндөрт өргөж явах (Honour)
- Үүрэг хариуцлагатай байх, зарчимдаа үнэнч байх (Duty and Loyalty)
- Өөрийн сэтгэлийн хөдлөлөө хянаж чадах (Self-Control)
- Бусад дэд ёс суртахуунууд (хөдөлмөрч, цаг барих зэрэг бидний сайн мэдэх япончуудын зан чанарууд энд багтана)

Хууль эрх зүйн орчин

Япон Улс 1890 онд Эзэн хаан Боловсролын тухай зарлиг гаргасан ба энэхүү зарлигаар зайлшгүй эзэмших шинэ боловсролын тогтолцооны өөрчлөлтөд Японы үнэт зүйлийг гол болгон баримтална гэж тунхагласан байна. Энэ нь үнэнч зүтгэл, ахмадын хүндэл, гэр бүлийн гишүүд, хань ижил, анд нөхөдтэй тогтоосон харилцаа зэрэг ёс суртахууны чанаруудыг чухалчлахыг сануулсан зарлиг байжээ.

Үндсэн хуулийн 26 дугаар зүйлд “Бүх хүн хуульд заасны дагуу өөрийн ур чадварт тохирсон тэгш боловсрол эзэмших эрхтэй. Бүх хүн өөрийн асран хамгаалалтад байгаа хүүхдийг хуульд заасан ерөнхий боловсролтой болгох үүрэгтэй. Заавал эзэмших боловсрол үнэ төлбөргүй байна” гэж заажээ. Үндсэн хуульд заасан энэ бодлогод тулгуурлан 1947 оны 03 дугаар сард Боловсролын суурь хуулийг баталсан бөгөөд тус хуулиар боловсролын салбарт баримтлах дараах дөрвөн зарчмыг дэвшүүлэн тавьсан байна. Үүнд:

- Хүмүүжүүлэх зорилгод тулгуурласан боловсролын бодлого;
- Боловсролын тэнцүү боломж ба хүйсийн тэгш байдал;
- Сургуулийн ардчилсан, үл ялгаварлах тогтолцоо;
- Үнэ төлбөргүй олгох заавал эзэмших боловсролын 6-3 тогтолцоо (6 жилийн бага сургууль, 3 жилийн дунд сургууль).

Мөн хуулиар сургуулийн насны бүх хүүхдэд заавал эзэмших боловсрол буюу 9 жилийн боловсролыг үнэ төлбөргүй олгох, нийгмийн боловсрол, гэр бүлийн боловсрол олгох тухай зохицуулалт, улс төрийн боловсрол, шашны боловсрол олгоход хориглох зарим зохицуулалтыг тус тус тусгасан байна. Мөн үндэсний болон орон нутгийн боловсролыг зүй зохисгүй байдлаар хянахыг хориглосон байна.

Япон Улсын суурь боловсролын тухай хуулиар ёс суртахуун, ёс зүйн боловсролыг заавал эзэмшүүлэх албан боловсрол гэж заасан бөгөөд энэ нь Японы үндэсний өв, соёлтой салшгүй холбоотой юм. Ёс зүйн боловсрол нь тухайн сурагч Япон орны үнэт зүйлийг таньж ойлгох, улмаар өөрийн орны соёл, уламжлалыг хадгалах, үнэт зүйлээ өвлүүлэн авч явах иргэнийг төлөвшүүлэх зорилготой юм. Иймд ерөнхий боловсролын сургуульд ёс зүй, ёс суртахууны боловсрол олгоход маш их анхаардаг байна.

Нийгмийн боловсролын тухай хуулийн (Social Education Law)⁹³ зорилт нь төрийн захиргааны болон орон нутгийн захиргааны байгууллагуудын нийгмийн боловсролыг хангах номын сан, музей, олон нийтийн боловсрол олгох танхимаар дамжуулан нийтийг соён гэгээрүүлэх ажлын чиг үүргийг тодорхой болгоход оршино. Тус хуулийн дагуу Kominkan буюу нийгмийн боловсрол олгох байгууллагууд олон нийтийг соён гэгээрүүлэх, ёс зүйн боловсрол олгох төрөл бүрийн үйл ажиллагаа явуулдаг байна. Ойролцоогоор 70,000 гаруй нийгмийн боловсрол олгох байгууллага байна. Тэдгээр байгууллагын төсвийг тухайн орон нутгийн захиргаа төсөв санхүүг хариуцан ажилладаг байна. Тус байгууллагууд ашгийн бус үйл ажиллагаа явуулна.

Номын сан – Номын сангийн тухай хуулиар номын сан нь нийгмийн боловсрол олгох байгууллага мөн гэж заасны дагуу олон нийтийг мэдээллээр хангах томоохон хэрэгсэл болдог.

Музей – Соёлын биет болон биет бус зүйлээр олон нийтийн өв соёлын мэдлэгийг тэлэх, эх оронч үзлийг суулгах, түүх соёлыг түгээн дэлгэрүүлж олон нийтийг соён гэгээрүүлэх үүрэгтэй гэх мэтчилэн чиг үүргийг нь тодорхойлж өгсөн байдаг.

⁹³ Social Education Law <https://www.hurights.or.jp/archives/asiapacific/section1/pdf/Social%20Education%20and%20Kominkan.pdf>

*Олон нийтийн боловсрол олгох байгууллага*⁹⁴ – Тус байгууллагууд нь боловсролын суурь хуульд зааснаас бусад нийгмийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх олон төрлийн үйл ажиллагаа явуулна.

Боловсролын суурь хуульд хамгийн сүүлд 2006 оны 12 дугаар сард нэмэлт, өөрчлөлт орсон байх бөгөөд боловсролыг тойрсон асуудал, шинжлэх ухаан, технологийн дэвшил, мэдээллийн дэвшилтэт технологи, хөгширч буй нийгэмд нөлөөлж буй байдал, гэр бүлийн амьдралын хэв маяг, хүүхдийн хүрээлэн буй орчны өөрчлөлт зэрэг олон асуудлууд урган гарснаар зайлшгүй нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага тулгарсан байна. Гэхдээ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа өмнөх хуулиар тогтоосон нийтлэг зарчим, Японы уламжлал, соёлыг уламжлан үлдээсэн байна. Хуульд заасан боловсролын суурь бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор 2008 оны 07 дугаар сард Засгийн газраас “Боловсролыг дэмжих үндсэн төлөвлөгөө”-г боловсруулан баталсан. Энэ төлөвлөгөөг 10 жил тутам шинэчлэн боловсруулахаар тогтсон ба уг төлөвлөгөөгөөр дараагийн 10 жилд хэрэгжүүлэх үндсэн чиглэлийг тогтоодог.

Боловсролыг дэмжих үндсэн төлөвлөгөө 2023 он (Basic Plan for the Promotion of Education)⁹⁵

Нийгмийн боловсролд чиглэсэн асуудлаар энэ удаагийн төлөвлөгөөнд:

- Тогтвортой нийгмийг дэмжих – Ирээдүйн нийгэм бүтээгчдийн санаачилгатай байдал, манлайлал, бүтээлч байдал, асуудлыг зөв шийдвэрлэх чадвар, логик сэтгэлгээ, өөрийгөө илэрхийлэх чадвар, үнэт зүйлсээ тодорхойлох чадварыг сайжруулах тал дээр олон ажлыг эрчимжүүлэх;
- Өв соёлоо дээдлэн сайн сайхан амьдралын хэв маягийг сайжруулах – Эрүүл мэнд, аюулгүй орчин, насан туршийн боловсролыг нийгмийн боловсролоор дамжуулан түгээх гэсэн 2 зорилт тавин шат шатны байгууллагуудад уг зорилтыг хэрэгжүүлэхийг тусгажээ.

Япон Улсын хувьд боловсролд оруулсан хувь хөрөнгө оруулалтыг хувь хүнд бус нийгмийн хөгжлийн үндэс гэж үздэг байна. Тиймээс ирээдүйн симбиотик нийгмийг хөгжүүлэх, шинэ үеийн үнэ цэнийг болгох тал дээр маш их анхаардаг.

Бага, дунд боловсролын түвшинд

Бага боловсролыг үндэс суурийг тавихдаа цэцэрлэгийн наснаас эхлэн Япон Улсын иргэн, үнэт зүйлийн мөн чанар, өв соёлыг ойлгуулах

⁹⁴ Educational system practice in Japan https://www.criced.tsukuba.ac.jp/keiei/kyozai_ppe_f3.html#5

⁹⁵ Basic Plan for the Promotion of Education

тал дээр эцэг эхтэй хамтран цогц хөтөлбөрөөр хангаж ажилладаг. Сургуулийн наснаас эхлэн ёс суртахууны хичээлийн мөн цогц хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хичээл орж эхэлнэ.

Ахлах, коллеж, их дээд боловсролын түвшинд

Ёс зүйн хичээлээр “Нийгэмд нээлттэй хөтөлбөр” гэсэн тусгайлсан хөтөлбөрийн хүрээнд ёс суртахууны боловсролыг дэмжин, сурган хүмүүжүүлэх, олон нийтэд тустай соён гэгээрүүлэх төрөл бүрийн ажил хийлгэдэг. Жишээлбэл;

- Амьдралын аюулгүй байдлын боловсрол
- Уламжлал соёлын боловсрол
- Эрүүл мэндийн боловсрол
- Сэтгэлгээ хөгжүүлэх соёл урлагийн боловсрол
- Ёс зүйн боловсрол
- Бие бялдрын хөгжлийн боловсрол гэх мэт олон хөтөлбөрүүд хэрэгждэг байна.

Үүнээс гадна насанд хүрэгчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, гадаадын иргэд, цагаач иргэд гэх мэт зорилтот бүлгийн нийгмийн боловсролыг хангах хүрээнд төр болон орон нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшлийн байгууллагууд ихээхэн анхаарч ажилладаг.

Боловсролын тогтолцоо

Орчин үеийн боловсролын тогтолцоо үүссэн цагаас “**Ёс зүйн хичээл**”-ийн хөтөлбөрийг тогтвортой баримталж, гэр бүл, сургууль, нийгмийн орчинд нэгдмэл байдлаар тусгаж ирсэн.

Ёс суртахууны хичээлийн үндсэн зорилго нь тухайн сурагч Япон орны үнэт зүйлийг таньж ойлгох, улмаар өөрийн орны соёл, уламжлалыг хадгалах, үнэт зүйлээ өвлүүлэн авч явах иргэнийг төлөвшүүлэх юм. Гэр бүл болон сургууль хоёр хослон нийтлэг үнэт зүйлсийг төлөвшүүлэх, хөгжүүлэхэд оролцдог нь тухайн бүс нутгийн ёс суртахууны боловсролын нэг онцлог болдог байна.

Ерөнхий боловсролын сургуульд **ёс суртахууны** хичээлийг дараах 4 төрлийн агуулгад тулгуурлан заадаг.⁹⁶

1. Өөрийнхөө тухай: Хүн бүр бие даасан байх, өөрсдийн хийж чадах зүйлээ хийх, хэм хэмжээтэй амьдрах;
2. Бусад хүмүүстэй харилцах харилцаа: Хүмүүстэй шударга, эелдэг харилцах;

⁹⁶ Moral education in Japan <https://www.nier.go.jp/English/educationjapan/pdf/201303MED.pdf>

3. Байгаль, эрхэм дээд зүйлтэй харилцах: Байгалийн гамшиг, байгаль, амьтны ач холбогдлыг мэдрэх;
4. Нийгэм болон бүлгүүдийн тухай: Олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, дүрэм журмаа дагах, амлалтаа биелүүлэх.

Бага ангийн хичээлийн хөтөлбөрт япон хэл, нийгэм судлал, математик, шинжлэх ухаан, амьдрах орчин, хөгжим, зураг, гар урлал, биеийн тамир, гэрийн аж ахуй гэсэн хичээлүүд багтдаг. Мөн нэмэлтээр **ёс суртахууны хичээл** ордог.

Дунд ангийн хичээлийн хөтөлбөрт япон хэл, нийгэм судлал, математик, шинжлэх ухаан, хөгжим, зураг, биеийн тамир, үйлдвэрлэлийн урлаг, гэрийн аж ахуй, **гадаад хэл**, сонгон судлах хичээлүүд багтдаг. Мөн нэмэлтээр **ёс суртахууны хичээл** орно⁹⁷.

Хүснэгт 2. Бага болон дунд ангид судлах хичээлийн цаг

ХИЧЭЭЛИЙН ТӨРӨЛ	АНГИ								
	1	2	3	4	5	6	7	8	9
Япон хэл	272	280	235	235	180	175	140	140	105
Нийгэм судлал	-	-	70	85	90	100	105	105	140
Тоо бодлого	114	155	150	150	150	150	-	-	-
Математик	-	-	-	-	-	-	140	105	140
Шинжлэх ухаан	-	-	70	90	95	95	105	140	140
Амьдрах орчин	102	105	-	-	-	-	-	-	-
Хөгжим	68	70	60	60	50	50	45	35	35
Зураг, гар урлал	68	70	60	60	50	50	-	-	-
Өрхийн эдийн засаг	-	-	-	-	60	55	-	-	-
Биеийн тамир	90	90	90	90	90	90	-	-	-
Уран зураг	-	-	-	-	-	-	45	35	35
Эрүүл мэнд, биеийн тамир	-	-	-	-	-	-	105	105	105
Үйлдвэрлэлийн урлаг, гэрийн урлаг	-	-	-	-	-	-	70	70	35
Гадаад хэл	-	-	-	-	-	-	140	140	140
Ёс суртахуун	34	35	35	35	35	35	35	35	35
Дүгнэлт хичээл	-	-	105	105	110	110	50	70	70
Сонгон судлах хичээл	34	35	35	35	35	35	35	35	35
НИЙТ /ЖИЛД/	782	840	910	945	945	945	1015	1015	1015

2.4. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Бүгд Найрамдах Солонгос Улс нь сургуулийн өмнөх боловсролын бодлого, хөгжлийн өнөөгийн чиг хандлага, хүртээмж, боловсролын салбарын хөгжлөөрөө олон улсад тэргүүлэгч орны нэг юм.

⁹⁷ Japanese educational system <https://www.studyinjapan.go.jp/en/planning/educational-system/>

Ард иргэдийн ёс зүй, соён гэгээрүүлэх үндэсний арга хэмжээнд гэр бүл болон сургууль гол үүрэгтэй байдаг ба энэ хоёр орчин хослон нийтлэг үнэт зүйлсийг төлөвшүүлэх, хөгжүүлэхэд оролцдог нь тухайн бүс нутгийн ёс суртахууны боловсролын нэг онцлог болдог байна.

БНСУ нь бусад улс орноос ялгарах гол ялгаа нь сайн иргэнийг бий болгох төлөвшүүлэхдээ дан ганц сургуулийн боловсролд анхаарах биш гэр бүлийн суурь хүмүүжлээр иргэдээ соён гэгээрүүлж, төлөвшүүлдэг. Иймд сургуульд ёс суртахууны боловсролыг холбогдох хөтөлбөрийн хүрээнд олгосон ч гэр бүлд мөн адил ёс суртахууны ойлголт, ухагдахуун байхгүй, гэр бүл, эцэг эхийн оролцоогүй бол төдийлөн үр дүнд хүрч чаддаггүй гэж үзэх нь элбэг байдаг. Учир нь гэр бүл буюу хүүхдийн ахуй орчин хүний ёс суртахууны төлөвшлийн суурь нь болдог гэж үздэгтэй холбоотой байна. БНСУ нь 51.7 сая хүн амтай⁹⁸ бөгөөд 24-35 насны хүмүүсийн 70 хувь нь дээд боловсролтой байгаа нь тус улсын ерөнхий боловсролын чанарын түвшнийг харуулж байна.

БНСУ нь сургалтын хөтөлбөрийг нийгэмд гарч буй өөрчлөлтүүдтэй уялдуулан хэрэгцээ, шаардлага болон шинээр гарч ирж буй мэдлэгийн салбар зэрэгтэй уялдуулан шинэчлэн боловсруулах бөгөөд тус улс сургалтын хөтөлбөрөө нийт 7 удаа шинэчилсэн байна. Хамгийн сүүлийн шинэчлэлийг 1997 оны 12 дугаар сарын 31-ний өдөр баталсан байдаг. Тус хөтөлбөрийг даяаршил болон мэдээлэлд суурилсан нийгмийн шаардлагад нийцүүлэхийг зорьсон ба уламжлалт сургалтын арга барил буюу мэдлэг, мэдээллийг олгодгоос гадна бие даан суралцах, сурагч тус бүрийн хэрэгцээ, шаардлагад тохирсон хэлбэрийг нэвтрүүлэх, өргөжүүлэх, хичээлийн ачааллыг бууруулах тал дээр анхаарсан байна.

Хууль, эрх зүйн орчин

БНСУ-ын Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлд⁹⁹

1. Иргэн бүр өөрийн чадамжид тохирсон боловсролыг эрх тэгш эзэмших эрхтэй.
2. Асран хамгаалагч, эцэг эх хүүхдийн заавал эзэмших боловсрол болон хуульд заасан бусад боловсролыг эзэмшихэд хариуцлага хүлээнэ.
3. Төрөөс бүх нийтийн боловсролыг үнэ төлбөргүй олгоно.
4. Боловсролын хараат бус байдал, мэргэжлийн ур чадвар, улс төрийн шударга байдал, дээд боловсролын байгууллагуудын бие даасан байдлыг хуульд заасан нөхцөлөөр баталгаажуулна.
5. Насан туршийн боловсролыг төр хариуцна.

⁹⁸ БНСУ-ын хүн амын тоон мэдээ, <https://www.worldometers.info/world-population/south-korea-population/>

⁹⁹ БНСУ-ын Үндсэн хууль, <https://www.law.go.kr/LSW/eng/engLsSc.do?y=16&x=22&menuId=1&query=education>

6. Боловсролын тогтолцоо, насан туршийн боловсрол, захиргаа, санхүү, багш нарын статус зэрэг боловсролтой холбоотой асуудлыг хуулиар зохицуулна гэж заасан байдаг.

Солонгос улсад иргэдийн боловсролын асуудлыг нийт 120 гаруй хууль тогтоомжоор зохицуулдаг бөгөөд эдгээрээс дараах хууль тогтоомж болон бусад хуулиар бүх нийтийн суурь боловсрол, иргэдийг соён гэгээрүүлэх арга хэмжээг *Насан туршийн боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Бага, дунд сургуулийн боловсролын тухай хууль* гэх мэт гол хууль тогтоомжоор зохицуулж байна.

Сургалтын хөтөлбөр

Шинэ хөтөлбөрийн хүрээнд бага сургуулийн 1 дүгээр ангиас ахлах сургуулийн 1 дүгээр анги (1-10 дугаар анги)-ийн үндсэн хөтөлбөрөөр хичээллэх бол ахлах сургуулийн 2-3 дугаар анги (11-12 дугаар анги)-д сурагчид өөрсдийн ирээдүйн зорилго, зорилтод нийцүүлэн сурах хичээлүүдээ сонгон суралцах юм.

Ёс зүй, ёс суртахууны ухагдахуун нь 1950-иад онд анх сургалтын хөтөлбөрт тусгагдсан бөгөөд цаг үе, нийгмийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагатай уялдан хэд хэдэн удаа өөрчлөгдсөн байна.

БНСУ-ын анхны бие даан баталсан Сургуулийн хөтөлбөрт (1955-1963) ёс зүйн боловсрол нь нийгмийн ухааны хичээлийн агуулгад багтаж байсан. Ёс зүйн хичээлийг Боловсролын яамнаас батлагдсан журмын дагуу зааж эхэлсэн бөгөөд ёс зүйн боловсрол нь иргэний боловсролд чиглэж байсан. 1973 онд ёс суртахууны хичээл нь сургалтын хөтөлбөрт бие даасан хичээл болж орсон бөгөөд улмаар 1974 онд ахлах сургуульд ёс суртахууны хичээлээр үндэсний ёс зүйг судалж эхэлсэн. Тухайн үед ёс зүйн хичээл социализмын нөлөөг эсэргүүцэх, эдийн засгийг сэргээх, үндэсний уламжлалыг сэргээхэд чиглэгдэж байсан.

1973-1982 онд ёс зүйн хичээл бага, дунд сургууль болон дээд сургуульд гэсэн гурван үндсэн чиглэлээр орох болсон. 1982-1988 онд уг хичээл заах арга бүрэн шинэчлэгдсэн бөгөөд хэлэлцүүлэг хэлбэрээр хичээл заагдах болсон. 1989-1994 онд нийгмийн ардчилсан байдал илүү тусгагдах болсон. 1995-1999 онд хүнлэг байдал, итгэл үнэмшил, ёс зүйн хүмүүжлийн үндсэн төлөвшил олгоход чиглэсэн. Энэ үеэс хоёр Солонгосын нэгдлийн тухай, Солонгос улс нэгдсэний дараа гэсэн хоёр үеийн амьдралын зорилгыг тусгайлан заах болсон, мөн *“national identity”* (үндэсний ондоошил, үндэстний ижилсэл, амин чанар)-ын томъёоллыг ёс зүйн хичээлийн агуулгад тусгасан.

Харин 2000 оноос буюу одоо мөрдөгдөж буй 7 дугаар сургалтын хөтөлбөрт “ethnic identity” (үндэсний ондоошил) гэх олголт их орсон байна. 7-10 дугаар ангийн ёс зүйн хичээлийн сурах бичгийн агуулгад дараах 4 хүрээг хамруулсан байна. Үүнд:

1. Хувийн амьдрал;
2. Гэр бүл, хөрш, сургууль дахь амьдрал;
3. Нийгмийн амьдрал;
4. Үндэсний болон хамт олны амьдрал.¹⁰⁰

Дээрх 4 агуулгад үндэсний ондоошил буюу “national identity” гэж тусгайлан томъёолоогүй ч 8, 10 дугаар ангийн сурах бичгийн 4 дэх хэсэг буюу “үндэсний болон хамт олны амьдрал”-д дээрх ойлголтыг тусгасан байна. Тухайлбал, 8 дугаар ангийн ёс зүйн сурах бичгийн “үндэсний болон хамт олны амьдрал” хэсэг нь 4 бүлгээс бүрдэж байна. Үүнд:

1. Солонгосын үндэсний хөгжил ба соёлыг эзэмшихүй (*Korean national development and cultural fluency*);
2. Төрийн болон үндэсний хөгжлийн ач холбогдол (*The importance of the state and national development*);
3. Төр, улс үндэстнийг зөв хайрлах (*Correct love of the state and nation*);
4. Нэгдэл ба Хойд болон Өмнөд Солонгосыг нэгтгэх хүч чармайлт (*Unification and strong will for the reunification of the North and South (Korea)*).

7 дахь сургалтын хөтөлбөрт орсон ёс зүйн хичээлийг ерөнхийд нь үзвэл Солонгос үндэс угсаа, хоёр Солонгосын нэгдэл болон даяаршил гэсэн 3 асуудлыг хөндсөн байна. Хэдийгээр эдгээр асуудлууд нь өмнөх сургалтын хөтөлбөрүүдэд багтаж ирсэн хэдий ч шинэ хөтөлбөр дээрх асуудлуудад харьцангуй их ач холбогдол өгсөн байна.

Боловсролын тогтолцоо

БНСУ-ын боловсролын систем нь бага сургууль, дунд сургууль, ахлах сургууль, их, дээд сургууль, мэргэжлийн дээд сургууль гэсэн тогтолцоотой байдаг бөгөөд дараах байдлаар суралцах жил, хичээлийн хөтөлбөрийг зохицуулсан байдаг.

Бага сургуулийн 6 жил: дунд сургуулийн 3 жилийн сургалт нь албан ёсны сургалт хэмээн тооцогдох бөгөөд үнэ төлбөргүй байдаг. Бага сургуулийн боловсрол нь суралцах дадал, өдөр тутмын амьдралд шаардлагатай анхан шатны чадвар эзэмшүүлэх, амьдралын үндсэн хэвшилд сургах, зөв

¹⁰⁰ Сургалтын хөтөлбөр VII

хүн болж төлөвшүүлэхэд чиглэсэн байдаг. 1 цагийн хичээл нь 40 минут үргэлжилдэг бөгөөд 1-2 дугаар ангид эх хэл, математик, зөв амьдрал, ухаалаг амьдрал, хөгжилтэй амьдрал зэрэг амьдралын үндсэн хэвшил, хэв маягийн хичээл орох бөгөөд 3-6 дугаар ангид эх хэл, нийгэм, ёс зүй, математик, байгалийн шинжлэх ухаан, хэрэглээний шинжлэх ухаан, биеийн тамир, дуу хөгжим, дүрслэх урлаг, англи хэл зэрэг хичээлүүдийг үзнэ.

Дунд сургуулийн сургалт 3 жил: Сурагчийг түүний гэрт хамгийн ойрхон сургуульд хуваарилдаг бөгөөд дунд сургуулийн боловсрол нь бага сургуультай адил заавал эзэмших боловсрол бөгөөд ямар нэгэн шалтгаанаар эцэг эх нь хүүхдээ дунд сургуульд сургахгүй бол хариуцлага хүлээж торгууль төлнө. Дунд сургуулийн сургалт нь бага сургуулийн боловсрол дээр үндэслэн сурагчдын сурах чадвар, амьдралд тустай үндсэн чадварыг хөгжүүлэн, ардчилсан нийгмийн иргэний хувьд мэдэх ёстой зүйлийг заах зорилготой.

Ахлах сургууль нь 3 жил: Дунд сургууль төгссөн болон мэргэжлийн шалгалтуудыг өгч тэнцсэн сурагч ахлах сургуульд орох эрхтэй. Ахлах сургууль нь энгийн ахлах сургууль, тусгай мэргэжлийн ахлах сургууль, мэргэжлийн ахлах сургууль, чөлөөт ахлах сургууль гэсэн 4 төрөлтэй байдаг. Элсэлтийн журам нь хот дүүрэг мөн сургууль тус бүр өөр байдаг. Ахлах сургуульд заавал сурах ёстой биш бөгөөд сургалтын төлбөр болон бусад зардлыг өөрсдөө хариуцдаг бөгөөд сургалтын төлбөр нь бүс нутаг, сургуулиасаа шалтгаалаад ялгаатай байдаг байна. Ахлах сургууль нь дунд сургуулийн боловсролын үр дүнд суурилан сурагчид өөрийн авьяас чадамжинд тохирсон ажил мэргэжил сонгох чадвар, дэлхийн иргэн болоход шаардлагатай чанарыг эзэмшүүлэхэд голлон анхаарна. 1 цагийн хичээл нь 50 минут үргэлжлэх бөгөөд эх хэл, математик, англи хэл, нийгэм, түүх, ёс зүй, байгалийн шинжлэх ухаан, биеийн тамир, урлаг, дуу хөгжим, дүрслэх урлаг, хөдөлмөр, гэр ахуй зэрэг хүмүүжлийн хичээлүүд ордог. Түүнчлэн сурагчид өөрийн хүссэн хичээлийг сонгон суралцах боломжтой. Бүтээлч биечлэн оролцох үйл ажиллагаа нь хичээлээс гадуурх үйл ажиллагаа бөгөөд сурагчид дугуйлан бүлгэм, ажил мэргэжилтэй танилцах хөтөлбөр, сайн дурын үйл ажиллагаа зэргээр дамжуулан бусдад туслах, бусдыг ойлгон хүндлэх зан төлөв суух ба өөрийн авьяас чадвар, нөөц бололцоог хөгжүүлэх чиглэлд илүү анхааран ажилладаг байна.

БНСУ нь дэлхийн иргэн бэлтгэх, ирээдүйн зөв, соёлтой иргэдийг бэлтгэх зорилгоор дараах багц агуулгыг сургалтын хөтөлбөрт тусгасан байдаг.

Хүснэгт 3. Боловсролын агуулга

Хичээлийн нэрс	1-2 дугаар ангийн хичээл	3-6 ангийн хичээл агуулга
Солонгос хэл	Солонгос хэл, математик, зөв амьдрал, у х а а л а г а м ь д р а л , х ө г ж и л т э й амьдрал	Сонсох, ярих, унших, хэлзүйн дүрэм, уран зохиол;
Нийгэм, ёс зүй		Улс төр, хууль, эдийн засаг, нийгэм соёл, газарзүй, газар нутаг, байгаль орчин, хүн ба амьдрал, тогтвортой ертөнц, ерөнхий түүх, улс төр, соёлын түүх, нийгэм эдийн засгийн түүх, өөрийгөө хүндэтгэх, бусадтай харилцах, нийгэм, хамт олны харилцаа;
Математик		Тоо, тоо бодлого, хэмжих нэгж, тогтмол ухагдахуун;
Байгалийн шинжлэх ухаан, хэрэглээний шинжлэх ухаан		Байгалийн шинжлэх ухааны хичээлээр “хөдөлгөөн ба энерги, бодис, амь нас, дэлхий ертөнц” гэх мэт, Хэрэглээний шинжлэх ухааны хичээлээр “хүний хөгжил, гэр бүл, гэр бүлийн амьдрал, аюулгүй байдал, нөөц баялагийг хянах, бие даах, техник, технологи ашиглах”;
Биеийн тамир		Эрүүл мэндийн боловсрол, сорилтыг даван туулах, аюулгүй байдлыг хангах;
Урлагийн хичээлүүд (дуу хөгжим, дүрслэх ухаан)		Мэдрэмжээ хөгжүүлэх, илэрхийлэх;
Англи хэл		Сонсох, ярих, унших, бичих;

Боловсролын дээрх агуулгаас гадна хүүхдийн бүтээлч байдлыг хөгжүүлэх, танин мэдэхүйн чиглэлээр тодорхой агуулга бүхий хөтөлбөр, үйл ажиллагааг явуулдаг.

Хүснэгт 4. Бүтээлч байдлыг хөгжүүлэх хөтөлбөрийн агуулга


Үйл ажиллагааны ангилал	Үйл ажиллагаа	Үйл ажиллагааны агуулга
Чөлөөт үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Шинэ орчинтой дасан зохицох үйл ажиллагаа; - Бүтээлч чадварын хөгжүүлэх үйл ажиллагаа; 	Сургуульд элсэхийн өмнөх шинэ орчинтой дасан зохицох үйл ажиллагаа болон шилжилтийн насны өөрчлөлтийг ойлгох, түүнд дасан зохицох үйл ажиллагаа;
Дугуйлан, хичээлээс гадуурх үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Урлаг, спортын үйл ажиллагаа; - Эрдэм шинжилгээ, соёлын үйл ажиллагаа; - Хүүхэд сурагчдын багаар ажиллах чадварыг хөгжүүлэх үйл ажиллагаа; 	Төрөл бүрийн туршлага, соёлын танин мэдэхүйн үйл ажиллагаагаар дамжуулан авьяас чадвараа хөгжүүлэх, шинийг эрэлхийлэх, мэдрэхүйгээ хөгжүүлэх, багаар ажиллах чадвар, туршлага хуримтлуулах, хүмүүстэй харилцах харилцааг хөгжүүлэх;

Сайн дурын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Бусдад туслах; - Байгаль орчин, хүрээлэн буй орчноо хайрлан, хамгаалах; - Олон нийтийн үйл ажиллагаа зохион байгуулж сурах; 	Сайн дурын үйл ажиллагааны утга учрыг ойлгох, бодитоор хэрэгжүүлж сурах;
Ирээдүйн ажил мэргэжилтэй холбоотой үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Өөрийгөө таньж мэдэх; - Ажил мэргэжлээ зөв сонгох, судлах; - Мэргэжлээ төлөвлөх; 	Олон төрлийн мэргэжлийг судалж, оролдож үзэх, ирээдүйд сонгох мэргэжлийнхээ талаар суурь мэдлэгтэй болох;

2.5. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС

Казахстан Улсын хувьд ёс зүйн үндсийг “Аль-Фараби”¹⁰¹-ийн гурвалжингаар тайлбарладаг бөгөөд “үнэнч зан чанар”, “шударга ёс”, “цэвэр сэтгэл” гэж гурван хэсгээс бүрддэг¹⁰² байна.

Зураг 1.Казахстаны ёс зүйн Аль-Фарабигийн гурвалжин



Эх сурвалж: Аль-Фараби гурвалжин
<https://textbook.tou.edu.kz/books/224/6en.html>

Дээрх гурвалжинд “шударга ёс” гэсэн ойлголт нь тухайн хүний дотоод дүр төрх нь цэвэр ариун байх ёстойг харуулж байна. “Үнэнч зан чанар”, “цэвэр сэтгэл” хүн бүрт байх ёстой гэж үздэг.

Ёс зүйн хэм хэмжээ нь амьдрал, нийгмийн салбарт зайлшгүй шаардлагатай нөхцөл бөгөөд ард түмний эв нэгдэлтэй амьдрах чадамжийн үзүүлэлт юм. Ёс зүй нь иргэдийн зан чанарт тавигдах ёс зүйн шаардлагууд гэж үздэг. Нийгэм дэх ёс зүйн үндсэн үүрэг бол хувийн харилцааны ёс суртахууны шаардлагад нийцүүлэн зохицуулах явдал юм.

Энэ утгаараа ёс зүй нь соёлын салшгүй хэсэг юм. Соёл үүсэх явцад хүнлэг зан үйлийн шинж тэмдгүүд нь ёс зүйн шаардлага болж хувирсан. Ёс суртахууны дүрэм, журмыг соёл иргэншлээс сонгодог.

¹⁰¹ Казахын Эрдэмтэн Аль-Фараби тайлбарласнаар “ёс зүй” гэсэн ойлголт нь бүх зүйлд анхаарал халамж тавих хэрэгцээг илэрхийлдэг гэжээ. Казахын ард түмэн нь түүх, хэл, соёл, үндэсний онцлог шинж чанараараа ялгаатай байдаг. Агуу гүн ухаантан, эрдэмтэн Абу Насир, Аль-Фараби нь Казахстаны ёс зүйг сайн, муу зүйлсийг хамруулан судалдаг шинжлэх ухаан гэж тодорхойлсон байдаг.

¹⁰² Аль-Фараби гурвалжин <https://textbook.tou.edu.kz/books/224/6en.html>

Эрдэмтэн Аль-Фарабигийн “Их хотын оршин суугчид» хэмээх зохиолд ёс суртахууны үндэс болсон 12 шинж чанарыг “Оюунлаг үндэстэн–2020” хөтөлбөртэй уялдуулж, оюутан, сурагчдын хөгжлийг төлөвшүүлэх, сэтгэн бодох чадварыг дээшлүүлэх, үзэл санаатай нийцүүлдэг байна. Үүнд:

1. Гүнзгий мэдлэг олж авах;
2. Мэргэжлийн ур чадвар;
3. Өндөр чадвар;
4. Үндэсний ашиг сонирхолд нийцүүлэх;
5. Ард түмний өмнө хүлээсэн үүргийг үзэл баримтлалд тулгуурлах;
6. Сайн үйлсийг урамшуулах;
7. Мэргэжлийн ур чадварт оюун санааны үнэт зүйлсийг ашиглах;
8. Бүтээлч байдал;
9. Орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглах;
10. Аж үйлдвэрийн хөгжил цэцэглэлт, мэдээллийн ахиц дэвшил;
11. Философийн шинэ эргэцүүлэл;
12. Ёс суртахуунтай байх, сайн сайхны төлөө тэмүүлэх зэрэг асуудлуудыг хамруулсан.

Дэлхийн өндөр хөгжилтэй 30 оронд эдгээр 12 чанарын индексийн үзүүлэлтүүдийг функциональ бичиг үсгийн эх үүсвэр болгон ашигладаг. Модернизмын орон зайд ёс зүйг чиглүүлдэг функциональ бичиг үсэг нь шинжлэх ухаан, боловсролын салбарын үзэл баримтлал юм. Функциональ бичиг үсэг бол прагматик ур чадвар бөгөөд тухайн мэргэжилтэй холбоотой өөрийн мэдлэгээ харуулах чадвар юм.

Дастаны¹⁰³ (яруу найргийн бүтээл) гол санаа нь: хүн бүр шударга ёс суртахуунтай байх явдал юм. Энэ нь дотоод болон гадаад хэв шинжийг багтаасан бөгөөд **анхны сургаал** гэж үздэг. Дотоод хэв маяг нь айл бүрийн дотоод ёс зүй, харин гадаад хэв маяг нь төрийн ёс зүй гэж үздэг. Эдгээр хоёр хэв маяг нь байнгын зохицол, харилцан үйлчлэлтэй байдаг.

Хоёр дахь сургаал нь: дотоод болон гадаад байдлын сайн сайхан багтана. Хүн бүрийн дотоод сайн сайхан нь дотоод оюуны чадавхын цогц гэж үздэг. Гадаад сайн сайхан нь дотоод байдлын үзүүлэлт болох объектив юм.

Гурав дахь сургаал нь: дотоод мэдлэгээс хуримтлагдсан саруул ухаан юм.

Дөрөв дэх сургаал нь: дотоод болон гадаад байдлын сэтгэл ханамж юм. Дотоод сэтгэл ханамж нь гэр бүлүүд сэтгэл ханамжтай байхыг хэлдэг бөгөөд гадаад сэтгэл ханамж нь нийгмийн улс төр, эдийн засаг, соёл,

¹⁰³ Дастан гэдэг нь түүх, домог гэсэн утгатай. Уран зохиол, яруу найргийн бүтээл юм.

нийгмийн хэрэгцээ шаардлагаас хамаардаг. Энэхүү үндэсний үзэл санаа нь Казахстаны орчин үеийн залуучуудын хүмүүжил, ёс зүйд ихээхэн хувь нэмэр оруулдаг байна.

Казах ёс зүйн онцлог шинж, төрлүүд

Ёс суртахуун нь удамшлын хувьд эцгээс үр хүүхдэд цусаар дамждаггүй. Ёс суртахуун тухайн хүнтэй хамт хөгждөг. Хүн чанар нь нэр төр, хүндэтгэл, агуу чанар зэрэг хувийн шинж чанаруудаар тодорхойлогддог бөгөөд энэ нь ёс зүй юм. Хүний өөрийн амьдралын хэв маяг, амьдралын хэм хэмжээ ёс зүйд үндэслэгдэнэ. Ёс зүй нь тухайн хүний зан чанарыг төлөвшүүлж, нийгэмд тустай, амьдрал нь хүн чанартай холбоотой байдаг бөгөөд хүнлэг байх мэдрэмж ёс зүйгээс эхэлдэг.

Казахстаны ард түмний өвөрмөц дүрэм нь ёс зүйн зарчимд суурилдаг. Казах ёс зүй нь хүн бүрийг удирдан чиглүүлдэг сайхан зан чанар, зарчим, дүрэм журмаар илэрнэ. Казах ард түмний ёс зүйн зарчмуудыг үнэт хэм хэмжээ гэж үздэг. Үүнд:

1. Зүрх сэтгэл, бодол санаа (зорилгын)-ны цэвэр байдал;
2. Харилцаанд өөрийгөө шууд, шударгаар илэрхийлэх чадвар;
3. Ухаалаг, тэнцвэртэй, тэвчээртэй байх;
4. Үндэстэн бүр, нийгмийн түвшин, иргэд хоорондын харилцааг сайн тогтоох;
5. Эелдэг, энэрэнгүй байх;
6. Бусдын баяр баясгалан, зовлонг хуваалцах чадвар;
7. Үнэт зүйлс дээр суурилсан хүмүүжил;
8. Өөрийнхөө муу чанаруудтай тэмцэх чадвар;
9. Даруу байдал, өгөөмөр сэтгэл, зоригтой байх;
10. Уучлах чадвартай байх.

Казах ёс зүйн төрлүүд

Даруухан байх ёс зүй. Казахуудын хийж буй үйлдэл их даруухан байх, харилцаа холбоо, зочдод хандах хандлага зэрэг ёс зүйг ихэд анхаардаг байна. Жишээлбэл: настан буурлууд үр хүүхэд, ач, зээгээ дагуулан олон нийтийн арга хэмжээнд оролцдог бөгөөд энэ нь хэрхэн даруу төлөв байхад сургах, мэргэн зүйр үг, зүйрлэсэн домог, үлгэр сонсгох, түүнээс үлгэр дуурайл хэрхэн авах, зан үйлийг үлгэрлүүлэн сургадаг ажээ.

Мэндлэх, хүндлэх ёс зүй. Энэ ёс зүй нь хэрхэн зөв мэндлэхээс эхлэх бөгөөд хүний оюун санаа, эелдэг байдал зэргийг соёлын үзүүлэлт гэж үздэг. Хүндэтгэсэн настан буурлуудтай залуус нь түрүүлж мэндлэх ёстой. Мэндчилгээний гол нөхцөл бол найрсаг байдал юм. Зөв мэндчилгээ нь

ярианы ёс зүйг төлөвшүүлэхэд ихээхэн тус болдог гэж үздэг. Мөн айл гэрийн эзэгтэй өндөр настантай толгой бөхийж мэндчилж байгаа нь асар их хүндэтгэлийг харуулж буй хэрэг юм.

Зочлох ёс зүй. Казахын ард түмэн зочломтгой зантай, зочдыг найрсгаж угтаж, таатай яриа өрнүүлдэг. Казахууд “конак кадэ” гэх бөгөөд энэ нь зочдоос дуу дуулуулах, сонирхолтой зүйлсийг яриулах, домбор хөгжим тоглуулах гэсэн утгыг илэрхийлнэ. Зочломтгой байдал, зочдыг хөгжөөх нь казах соёл, казах зан заншлын гол онцлог юм.

Ирсэн зочдыг дайлах ёс зүй. Ирсэн гийчин, зочдод шинэ малын махыг чанаж өгөх уламжлалтай. Чанасан махыг “табак” гэж нэрлэдэг бөгөөд энэ махаар зөв үйлчлэх нь тэдний ёслол юм. Табак бүр зочдын нас, нийгмийн байдал, цусан төрлийн холбооноос хамаарч хэд хэдэн төрөлд хуваадаг. Табак махны тодорхой хэсгээр (муше) тавьдаг. Хамгийн хүндэтгэлтэй хүнд толгой болон сүүжний махыг тавьж, каз тэргүүлсэн тавгийг тэргүүн ширээнд байрлуулна. Толгойн магнайн хуйхыг хөндлөн зүсээд тавагтай махны дээр нь байрлуулан гол зочид руу харуулна. Сүүж, шаантын барих талыг зочинд харуулж тавих учиртай. Харин хүргэн, бэрийн хувь өвчүү бөгөөд хүүхдийн хувь чих, бөөр, зүрх, шийр, залуу эмэгтэйчүүдийн хувь тагнай, хэл, хоньчны хувь шулуун гэдэс гэхчилэн оноодог байна.

Буян хийх ёс зүй. Бусдад өгөөмөр сэтгэлтэй байх нь ариун сэтгэлийн шинж бөгөөд энэ нь их чухал үнэт зүйл юм. Сайхан сэтгэлтэй хүн мэдрэмжтэй, үнэт зүйл, байгалийн сайхныг биширч, түүнд санаа тавьж, буян үйлддэг ёс бий.

Хүн байх ёс зүй. Хүн төрөлхтөн нь ариун нандин амьдралын хуулиудыг чин сэтгэлээсээ хүндэтгэн биелүүлж байдаг. Гагцхүү хүнээ хайрлах, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, сайн сайханд итгэх итгэл л хүн чанарын шинж гэж үздэг. Зөв зүйл хийх нь оюун санааны хувьд хөгжсөн хүн гэж үздэг. Биеийн ариун цэвэр болон сэтгэлийн ариун байдлыг хадгалах чадвар нь хувь хүний үнэ цэнэ гэж үздэг. Казахын ёс зүй нь үндэсний соёлын дүр төрх юм. Өсвөр, залуу үеийнхэнд хүмүүнлэг, төлөвшилийг сургахдаа Казах ард түмэн хууль тогтоомж болон уламжлал, ёс заншлаа даган мөрдөх, үүрэг даалгаврыг ягштал биелүүлэхийг заадаг.

Эрүүл амьдралд сургах ёс зүй. Эрүүл мэнд нь хөдөлмөрийн чадварыг тодорхойлох, хувь хүний хөгжлийг хангах бөгөөд хамгийн чухал хэрэгцээ юм. Тиймээс эрүүл амьдралын хэв маягийг ёс зүйтэй холбон авч үздэг.

Эх оронч үзэлтэй байх ёс зүй. Казах ард түмний үндэсний онцлог, уламжлал, соёл нь Казах хүн бүрийн чиглүүлдэг. Үндэстнээ хайрладаг хүн эх хэлээ эрхэмлэдэг, үндэсний бичиг соёлоо хайрладаг. Эх оронч үзэл

нь үндсэрхэг үзэл, өндөр ёс суртахуун, үндэсний бахархал юм. Үндэсний бахархал нь эрэлхэг, энэрэнгүй, бүтээлч, зоригтой, үндэсний нэр төр, хувь хүн бүрийн сэтгэлд зориулагдсан агуу хүч юм.

Ур чадварт сургах ёс зүй. Казахстан ард түмэн үндэсний хээ, хувцас оёх, сүлжмэл болон хатгамал урлах, хивс нэхэх, эсгий урлах, дуу дуулах, яруу найраг, үлгэр туурвих, ан агнуур хийх, спорт, бүжиг, хөгжим тоглох гэх мэт урлагийн ур чадвараа хөгжүүлж, чадварлаг байх нь ёс суртахууны шинж гэж үздэг.

Гэр бүлийн харьцаанд сургах ёс зүй нь хүн бүр төрсөн цагаасаа эхлэн гэр бүлд төлөвшдөг учраас хүн төрөлхтний түшиг тулгуур юм. Гэр бүл нь чухал бөгөөд ариун ёс суртахууны алтан сургууль гэж үздэг. Гэр бүлд эцэг эхчүүд харилцан хариуцлагатай үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хүүхдийн хүмүүжлийн чанаруудыг төлөвшүүлж чаддаг. Эцэг эхийн хоорондын харилцан хүндэтгэл, дэмжлэг, хүүхдийнхээ дэргэд тайван байх чадвар нь ёс зүйн гол шаардлагуудын нэг юм.

Үдэж өгөх ёс зүй. Казахстан ард түмэн хол, ойрын аялалд гарахаас шалтгаалаад салах ёс зүй өөр өөр байдаг. Салах ёс хийхэд ерөөл хэлэхийг голчлон ашигладаг. Ахан дүүс, найз нөхөд, хөршүүд нь гэр бүл, төрөл төрөгсдөө үдэж өгөхдөө зорьсон газраа саадгүй хүрэхийг хүсэн ерөөж, тэврэн үдэж өгөх уламжлалтай.

Хүүхэд, залуучуудын хүмүүжил, төлөвшил, ёс суртахууны боловсролын талаар хэрэгжүүлж буй хөтөлбөр

Казахстан Улсын хувьд хүүхэд, залуучуудын хүмүүжил төлөвшил, ёс суртахууны боловсролын тухай тусдаа хууль байхгүй, харин хөтөлбөр хэрэгжүүлдэг. Боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлд боловсролын системийн үүргийг тодорхойлсон бөгөөд энд хүмүүжил, төлөвшил, ёс суртахууны боловсролын талаар дараах заалтуудыг тусгасан байна.¹⁰⁴ Үүнд:

- Үндэсний болон хүн төрөлхтний үнэт зүйлд, мөн шинжлэх ухаан, технологийн ололт амжилтад тулгуурлан хувь хүнийг төлөвшүүлэх, хөгжүүлэх, мэргэжил дээшлүүлэхэд чиглэсэн чанартай боловсрол олгох нөхцөлийг бүрдүүлэх;
- Хувь хүний бүтээлч чанар, оюуны болон биеийн чадварыг хөгжүүлэх, зөв эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх, хувь хүнийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх замаар оюуны чадамжийг хөгжүүлэх;

¹⁰⁴ http://adilet.zan.kz/kaz/docs/Z070000319_ Aguzu billahi minashaitan nirajim bismillahi rahmani rahim Боловсролын тухай хууль, 11 дүгээр зүйл

- Иргэний болон эх оронч үзэл, Эх орон– Бүгд Найрамдах Казахстан Улсыг хайрлах, төрийн бэлгэ тэмдэг болон төрийн хэлийг эрхэмлэх, үндэсний ёс заншлыг хүндэтгэх, Үндсэн хуульд харшилсан болон нийгмийн эсрэг аливаа үйлдлийг үл тэвчих чанаруудыг төлөвшүүлэх;
- Идэвх санаачилгатай хувь хүнийг төлөвшүүлэх, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын арга хэмжээнд оролцох, хувь хүний эрх ба үүргийн талаарх ухамсартай үзэл бодлыг төлөвшүүлэх;
- Үндэсний болон дэлхийн соёлын ололттой танилцах, Казах үндэсний болон улс дахь бусад үндэстний түүх, зан заншил, ёс журмын талаар судлах, мөн төрийн хэл, орос болон гадаад хэл сурах нөхцөл боломжуудыг бүрдүүлэх юм.

Хөтөлбөрийн зорилго нь: хүний дотоод ертөнцийг нээснээр зөв боловсон хүн болж төлөвшихөд дэмжлэг үзүүлэх, эрхэм дээд чанарт сургах, амьдрах чадвар болон боломжийг хөгжүүлэхэд оршино. Түүнчлэн бодол санаа, үг яриа, үйл хөдлөлөө зөв уялдуулах, ямар ч асуудлыг өөрийн болон бусдын тусын тулд оновчтой шийдэх, эх оронч үзлийг төлөвшүүлэх, хүний эрхийг хүндэтгэх чадварыг эзэмшүүлэх зорилготой.

“Өөрийгөө танин мэдэх” хөтөлбөрийн гол санаа нь хүүхэд, залуучуудыг ёс суртахуунтай байх, эрхэм чанараа хадгалахад сургахаас гадна, үндэстэн бүрийн, хүн бүрийн хамгийн сайн сайхан, гэгээлэг, ариун чанарыг улам хөгжүүлэхэд оршино.

Хөтөлбөрийг Казахстан Улсын боловсролын системд нэвтрүүлснээр “Өөрийгөө танин мэдэх” хичээлийн хөтөлбөрийг бий болгож, 2010 оноос эхлэн хэрэгжүүлсэн. Хичээлийн агуулга нь хүний мөн чанарт тулгуурласан бөгөөд өөрийн эрхэм чанарыг мэдрэх, өөрийгөө хүндэтгэх, үзэл бодлоо чөлөөт илэрхийлэх, өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээг ойлгуулан хүмүүжүүлэхийн зэрэгцээ амьдралд зүг чигээ зөв тодорхойлох, шийдвэр гаргах, хариуцлагаа ухамсарлах чадварыг хөгжүүлэхэд оршино. Бүх насны хүүхдүүд, сурагчид болон оюутнууд оролцогсод нийт дүнгээр 37,901 хүн болсон бөгөөд танин мэдэхүйн багш нар 747 хүнийг тус тус¹⁰⁵ хамруулсан байна.

Ёс суртахуун, оюун ухааны сургалт, боловсрол, шинжлэх ухааны портал хуудас «Самопознание.KZ» www.ozin-oz-tanu.kz нээж, хүүхэд залуучууд өөрийгөө танин мэдэх, нээх, найз нөхөдтэй болох, үлгэрлэн дуурайл үзүүлэх, бусдад нөлөөлөх, номоос ашиг тус хүртэх, сургаал үгс, үлгэр, түүх, зүйрлэл, цахим номын сан гэх мэтчилэн хэрэгтэй мэдээллүүдийг ашиглахад ойлгомжтой байдлаар байршуулсан байна.¹⁰⁶ Үүний үр дүнд

¹⁰⁵ <http://ozin-oz-tanu.kz/p/history>

¹⁰⁶ <http://school.ozin-oz-tanu.kz/learn/show/id/110>

сурган хүмүүжүүлэх туршлага хуримтлуулах, туршлага судлах, улмаар хамгийн тохиромжтой туршлагыг сонгож, цаашид хэрэгжүүлэх ач холбогдолтой.

Сургуулийн өмнөх боловсролын түвшинд¹⁰⁷

“Өөрийгөө таних” болон “Бөбек” хөтөлбөрүүдийн хүрээнд 2009 оноос “Өөрийгөө таних” тусгай цэцэрлэгүүд ажиллаж эхэлсэн. Зорилго нь хүүхдийг бүх талаар цогц хөгжүүлэх бөгөөд хүүхдэд зориулсан аливаа үйл ажиллагаанд хүний үнэт зүйлсийн талаарх ойлголтыг ухаж ойлгуулах, хүүхдийн өөрийгөө таних болон өөрийн чадварыг мэдэрч ойлгох чадамжийг идэвхжүүлэн хөгжүүлэхэд оршино.

Уг цэцэрлэг нь хүүхдэд мэдлэг боловсрол олгох, хүүхдийг хүмүүжүүлэх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах ба чийрэгжүүлэх зэрэг цогц сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг “Өөрийгөө таних” хөтөлбөртэй уялдуулан явуулах боломжоор бүрэн хангагдсан. Цэцэрлэгийн багш сурган хүмүүжүүлэгч, эцэг эх, хүүхдүүдэд чиглэсэн бүх үйл ажиллагааг “Өөрийгөө таних” хөтөлбөртэй уялдуулж явуулдаг.

Сургуулийн өмнөх насны хүүхдийг сурган хүмүүжүүлэх хичээлийн хөтөлбөрийн агуулга нь хүүхдийн байнгын өдөр тутам хийдэг гол үйлдэл буюу тоглох үйлдлээр дамжуулан мэдлэг боловсрол олгох, төлөвшүүлэн хүмүүжүүлэхэд чиглэсэн.

“Өөрийгөө танин мэдэх” цэцэрлэгт хүүхдийг зөв боловсон сурган хүмүүжүүлэх, төлөвшүүлэх үйл ажиллагаанд эцэг эхийн үүрэг, оролцоо нэн чухал үүрэгтэй. Эцэг эхтэй хамтран ажиллах зорилгоор “Нээлттэй хаалга” буюу эцэг эхэд зориулсан өдөрлөгийг тогтмол зохион байгуулдаг. Уг арга хэмжээ нь хүүхдүүд хайр халамжтай, сайхан сэтгэлтэй байх, мөн бусадтай харилцан ойлголцоход хэрхэн суралцан хүмүүжиж буйг эцэг эхчүүдэд харуулах зорилготой.

“Өөрийгөө таних” хөтөлбөрийг сургуулийн өмнөх боловсролд хэрэгжүүлснээр хүүхдүүд хүнлэг зан чанарын тухай ойлголт авч, сайн сайхан үйл хийж сурахын зэрэгцээ аливаа зүйлд ухамсартай хандаж сурах юм.

Бага, дунд боловсролын түвшинд

Өөрийгөө таних замаар мэдлэг боловсрол олгохын зорилго нь суралцагчийн үнэт зүйл, зөв дадал зуршлыг хөгжүүлэх, өөртөө хандах болон хүрээлэн буй орчинтой, хүн төрөлхтөнтэй харьцах хандлагыг,

107

улмаар хүнлэг зан чанар, нийгэмд ач тустай хандлагыг хэвшүүлэх, өөрийн сонирхлыг нээх, амьдралын зорилгыг тодорхойлох, хүнлэг сонголт хийх, мөн хэлсэн үг болон үйлдэлдээ хариуцлагатай байхыг төлөвшүүлэхэд оршино.

Хичээлийн агуулгыг хүний үнэт зүйлд үндэслэн боловсруулсан бөгөөд дараах агуулгын хүрээнд боловсрол олгох юм. Үүнд:

- хайр сэтгэл, эрүүл мэнд, эрх чөлөө, аз жаргал, хөдөлмөр, бие болон сэтгэлийн уялдаа холбоо, амьдралын зорилго, хүний үүрэг хариуцлага, мөн санаа бодол, үг яриа, үйл хөдлөлийн уялдаа холбоог бүрэн гүйцэд ойлгуулах замаар өөрийгөө таних;
- гэр бүл, найз нөхөд, хүндэтгэл, эрх тэгш байдал, халуун дотно харьцаа, харилцан ярилцах, харилцан ойлголцох, эв найрамдалтай байхын утга учрыг бүрэн гүйцэд ойлгуулах замаар бусдыг таних;
- байгаль орчин, эх орон, амьдрал болон хүрээлэн буй орчинтойгоо уялдан зохицох, итгэл найдвар зэрэг ойлголтыг бүрэн гүйцэд авснаар дэлхий ертөнцийг таних;
- шударга үнэн, бүтээлч байдал, соёл урлаг, хүн төрөлхтний эв нэгдэл, “хүн төрөлхтөн эх дэлхий хэмээх нэгэн дээвэр дор хамт амьдардаг”-ийг бүрэн гүйцэд ойлгуулах замаар хүн төрөлхтний оюуны бүтээл, мэдлэг туршлагын талаар таньж мэдэх юм.

Бага дунд боловсролын түвшинд боловсруулсан хичээлийн хөтөлбөр нь хүний үнэт зүйлсийн тухай үндсэн ойлголтуудыг хөгжүүлэхэд тасралтгүй байдлыг хангах буюу дэс дараатай мэдлэг олгоход чиглэсэн.

Хичээлийн хөтөлбөр нь *“өөрийгөө таних”, “нийгэм дэх хүн”, “хүн ба хүрээлэн буй орчин”, “хүн төрөлхтний оюуны бүтээл, мэдлэг туршлага”* гэсэн 4 хэсгээс бүрддэг. Эдгээр сэдвүүд нь улс орнуудын урлаг соёл, түүх, ёс заншлыг хүндэтгэх, хүн төрөлхтний эв нэгдлийн талаар ойлгуулах зорилготой. Жишээ нь агуу хүмүүсийн амьдралыг танилцуулснаар сурагчид хүн, хүрээлэн буй орчинтой хэрхэн зохицох талаарх ойлголтыг эзэмших юм.

Коллеж, их, дээд боловсролын түвшинд

“Өөрийгөө таних” хөтөлбөрийн хүрээнд түүхэнд нэрээ мөнхөлсөн эрдэмтэн мэргэдийн амьдрал, тэдний хэлсэн сургаал үгсийн мөн чанарыг таниулах замаар суралцагчийн дотоод ертөнцийг нээхийг зорьдог. Ингэснээр нийгмийн өмнө хариуцлагаа ухамсарладаг, идэвхтэй, бүтээлч, хүнлэг, хөдөлмөрч хойч үеийг төлөвшүүлэх юм.

Хичээлийн хөтөлбөрийн зорилго:

- Оюутнуудын дотоод ертөнцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Зан чанарыг нь төлөвшүүлэх, өөрөөр хэлбэл, хариуцлага, нэр төр, төлөв даруу зэрэг хүнлэг чанаруудыг төлөвшүүлэх;
- Сурч мэдсэн зүйлийг амьдралд хэрэгжүүлж хэвшүүлэх;
- Хүн болон хүрээлэн буй орчинд сайн үйл хийхийг сургаснаар ирээдүйд ажил мэргэжилдээ дуртай, бүтээлч боловсон хүчнийг бэлтгэх, тэдний мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх зэрэг болно.

Хичээлийн хөтөлбөрт буй гол онцлог нь хүмүүжлийн асуудлыг мэдлэг боловсрол олгохоос чухалд тавьсан бөгөөд мэдлэг боловсролыг хүмүүжил дотор багтаасан. Өөрөөр хэлбэл, боловсрол олгох нь хүмүүжлийн нэг асуудал юм. Хичээлийн хөтөлбөрийн агуулга нь хүний үнэт зүйлсийг нээх зорилготой.

Суралцагчийн идэвхийг нэмэгдүүлэх, мэдлэг боловсрол болон хүмүүжил төлөвшлийг хүртээмжтэй олгох үүднээс сургалтын онцлог арга барилуудыг хэрэглэж байна. Үүнд:

- Сайхан сэтгэгдэл төрүүлэх: Хичээл орж эхлэх болон дуусахад сэтгэл ханамжтай байх, сэтгэл санаа тайван байх;
- Хичээлийн эшлэл: Зөв зүйтэй санал бодол, шүүмжлэлийн талаар авч үзэх;
- Яриа хэлэлцүүлэг өрнүүлэх: Хүмүүжлийн ач холбогдолтой сэдвээр яриа хийх;
- Бүтээлч ажил, багаар ажиллах: Ач холбогдолтой тоглоом тоглох, жүжигчилсэн тоглолт хийх, зураг зурах, шүлэг зохиох, зохион бичлэг бичих, дуу зохиох гэх мэт;
- Хөгжимтэй болон нийтээр дуулах: багаар ажиллаж сурах, эв нэгдэлтэй байх зэрэг болно.

“Өөрийгөө таних” хөтөлбөрт тусгасан чухал асуудлын нэг багш нарын үүрэг оролцоо юм. Ёс зүй, хүмүүжил, төлөвшлийн боловсрол олгоход хүний эрхэм чанаруудыг өдөр тутмын амьдралд хэрэгжүүлж хэвшүүлснээр үр дүнд хүрдэг. Үүнд багшийн үүрэг оролцоо чухал ач холбогдолтой. Багшийн хандлага зөв байвал сурагчид нь зөв төлөвших юм.

Төрийн албаны ёс зүй

БНКаЗ Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 153 дугаар зарлигаар Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг баталсан. Төрийн алба нь нийгэм, төрийн илэрхийлэл бөгөөд төрийн албан хаагчийн албаны ёс зүйд өндөр шаардлага тавьдаг.

Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм нь төрийн албан хаагчийн албаны ёс зүйн хэм хэмжээг тогтоож, төрийн байгууллагад итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэх, төрийн албанд харилцааны өндөр соёлыг төлөвшүүлэх, уур амьсгалыг бүрдүүлэхэд чиглэгдэх, итгэл үнэмшил, төрийн албан хаагчийн ёс зүйгүй үйлдлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Төрийн албан хаагчийн ёс зүйд¹⁰⁸ дараах зарчмууд орж байна. Үүнд:

- **итгэл үнэмшил:** төрд хичээнгүйлэн зүтгэх;
- **үнэнч шударга байдал:** ажил үүргээ гүйцэтгэхдээ чин сэтгэлээсээ хандах;
- **шударга ёс:** хувь хүн, хуулийн этгээд, олон нийтийн бүлэг, байгууллагын нөлөөллөөс үл хамааран хууль ёсны шийдвэр гаргах, аливаа нөхцөл байдалд нэг талыг барьсан, субъектив байдлаар ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх;
- **ил тод, нээлттэй:** олон нийттэй хамтран ажиллах хүсэл эрмэлзэл, үйл ажиллагааны ил тод байдлын баталгаа;
- **зелдэг байдал:** иргэд, хамтран ажиллагсдадаа зөв, хүндэтгэлтэй хандах;
- **ажлын чиглэл:** төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээ авах, төрийн үйлчилгээний эрэлт хэрэгцээнд бүрэн анхаарлаа хандуулах, өргөдөл хүлээн авахдаа хүнд суртал гаргахаас урьдчилан сэргийлэх.

Төрийн албан хаагчдад дараах шаардлагуудыг тавина:

- даруу байдал, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахуун, ёс суртахууны хэм хэмжээг дагаж мөрдөх, бодит байдалд нийцэхгүй мэдээллийг түгээхгүй байх;
- улс орны эрх ашиг, иргэдийн эрх ашгийг хохироосон үйлдлээс урьдчилан сэргийлэх;
- хууль эрх зүйг дагаж мөрдөх, ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх;
- иргэдтэй харьцахдаа зөв хандах, бүдүүлэг, доромжлох, буруу авир гаргахаас урьдчилан сэргийлэх, үйлдэл;
- хуралдааны протокол, албан ёсны дүрмийг дагаж мөрдөх, төрийн байгууллагын нэр төр, эрх мэдлийг гутаах үйлдлээс урьдчилан сэргийлэх;
- албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой хууль бус амлалт, хууль бус үүрэг хүлээхгүй байх;
- төрийн байгууллага, төрийн албан хаагч болон бусад этгээдийн үйл ажиллагаанд хувийн асуудлаа шийдвэрлэхэд албан

¹⁰⁸Казахстаны Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм https://egov.kz/cms/en/articles/state_service/ethic_code

тушаалаа ашиглахгүй байх, түүнчлэн олон нийт, шашны холбоо, ашгийн бус бусад байгууллагын ашиг сонирхлын үүднээс хандахгүй байх;

- аюулгүй байдлыг хангах, төрийн өмчийг зориулалтын дагуу ашиглах, албан үүргийн гүйцэтгэл, зөвшөөрөгдсөн бусад үйл ажиллагаа;
- албан үүргээ ухамсартай биелүүлэх, саад учруулсан санхүүгийн болон эд хөрөнгийн хууль бус ашиг сонирхлыг хэрэгжүүлэхгүй байх.
- албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой тохиолдлоос бусад мөрийтэй тоглоомын газарт зочлохгүй байх гэсэн шаардлагуудыг биелүүлдэг байна.

Төрийн албан хаагчийн ажлын байран дэх зан төлөвшилд дараах асуудлуудыг хамруулжээ. Үүнд:

- албан ажилдаа найрсаг харилцаа, бүтээлч хамтын ажиллагааг бий болгох, бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- төрийн болон бусад албан хаагч албаны ёс зүйн хэм хэмжээг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, бусад арга хэмжээ авах;
- хамт олны нэр төр, алдар хүндийг гутаан доромжлохоос зайлсхийх;
- шударга ёс, хувь хүний нэр төр, алдар хүндийг хүндэтгэх, үлгэр жишээ болох;
- төрийн албан хаагчийн нэр төр, алдар хүндийн эсрэг ялгаварлан гадуурхалт, зөрчлийг үгүйсгэсэн ёс суртахуун, сэтгэл зүйн таатай уур амьсгалыг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах;
- нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахуун, ёс зүйн хэм хэмжээнд нийцээгүй үйлдэл хийхгүй, бусдыг албадахгүй байх;
- хамт ажиллагсдаа үндэслэлгүй буруутгах, бүдүүлэг үг хэлэх, нэр төрийг гутаан доромжлох, эелдэг бус байдал, зохисгүй үйлдэл хийхээс урьдчилан сэргийлэх;
- хамт олонд шашны итгэл үнэмшлийг тулгахгүй байх, харьяа албан хаагчдыг олон нийтийн болон шашны холбоо, ашгийн бус бусад байгууллагын үйл ажиллагаанд оролцуулахгүй байх.

Төрийн албан хаагчид нь: төрийн бодлого, албан ёсны үйл ажиллагааны талаар төрийн бодлогын үндсэн чиглэлд нийцэхгүй, нийтэд мэдээлэхийг хориглосон, төрийн албан тушаалтан, төрийн захиргааны байгууллагад хандсан ёс зүйгүй мэдэгдэл, мэдээллийг нийтэд ил тод илэрхийлэхгүй байхыг энэ дүрэмд тусгасан байна. Төрийн албаны ёс зүйг зөрчихөөс урьдчилан сэргийлэх ажлыг төрийн албаны эрх бүхий байгууллага хууль тогтоомжийн дагуу зохицуулдаг байна.

Мөн Төрийн албаны тухай хуулийн 49-52 дүгээр зүйлд заасны дагуу **төрийн албан хаагчид ёс зүйн** дараах үүргийг хүлээнэ:

- хууль ёсны зарчмыг удирдлага болгох;
- төрийн албаны нэр хүндийг гутаах үйлдлээс урьдчилан сэргийлэх, төрийн бодлогод үнэнч байж, тууштай хэрэгжүүлэх;
- төрийн алба, төр, түүний байгууллагуудад итгэх олон нийтийн итгэлийг хадгалах, бэхжүүлэх;
- нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахуун, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх;
- БНКаЗУ-ын төрийн бэлгэдэлд хүндэтгэлтэй хандах хандлагыг үлгэр жишээ болох;
- албан тушаалынхаа бүрэн эрхээс хэтэрсэн тушаалын биелэлтийг харьяа төрийн албан хаагчдаас шаардахгүй байх;
- төрийн албан хаагчийн албан ёсны ёс зүйд заасан бусад ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх.

Эдгээрээс гадна төрийн албан хаагчийн ёс зүйн дараах 3 төрлийн зөрчлийг Төрийн албаны тухай хуульд тусгасан байна:

- төрийн албаны нэр хүндэд халдсан сахилгын зөрчил;
- ашиг сонирхлын зөрчил;
- авлигын хэрэг.

Төрийн албан хаагч нь эхний сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жилийн дотор сахилгын зөрчлийг давтан үйлдсэн бол төрийн албанаас халагдана. Мөн албан хаагч нь төрийн байгууллагад учруулсан шууд бодит хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.


2.6. БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛС

Энэтхэг Улс нь ёс зүй, ёс суртахууны талаар маш эртний түүхтэй бөгөөд Буддын шашинтай салшгүй холбоотой явж иржээ. Мөн Энэтхэгийн уламжлалт (Хиндү) амьдралын хэв маягаар хүн бүр өөрийн каст буюу давхаргад амьдарч тохирсон үүргээ биелүүлэх ёстой гэж үздэг. Энэ каст нь 4 давхаргатай (Брахманууд, Кшатри, Вайшья, Шудра) бөгөөд эдгээр давхаргынхан Дарма (Dharma) буюу нийгмийн дэг журам, ёс суртахууны хуульд захирагдах ёстой байдаг.¹⁰⁹ Харин одоогийн байдлаар Энэтхэгт албан ёсны 2 хөтөлбөр, 1 албан бус зан заншил мөрдөгдөн хэрэгжиж байна. Үүнд: Бүх нийтийн ёс зүйн боловсрол (Universal Ethics Education-UEE), Иргэний дүрэм (Citizen's Charter – Ethics Notes), Гандигийн ёс зүй-Махатма Гандигийн 11 зарчим (Gandhian Principles) зэргүүд байна.

¹⁰⁹ https://cbseacademic.nic.in/web_material/doc/ktpi/30_kpti%20xii%20-%20indian%20ethics_old.pdf

Бүх нийтийн ёс зүйн боловсрол (Universal Ethics Education-UEE)¹¹⁰

Энэ хөтөлбөр нь Дээрхийн Гэгээнтэн XIV Далай Ламын айлдсан нийтээр мөрдөх ёс суртахууны үзэл баримтлал дээр үндэслэсэн хөтөлбөр юм. Хөтөлбөрийн хүрээнд байгууллага болон олон нийтийн орчинд хүүхэд, залуучуудад зориулсан ёс зүйн сургалтыг боловсруулан хэрэгжүүлдэг. Хамрах хүрээний хувьд хүүхэд (4-14 насны хүүхдэд), багш, эцэг эх, олон нийтийн байгууллага зэрэг хүрээнд явагддаг.



Энэ хөтөлбөр нь 2014 онд боловсруулагдаж эхэлсэн бөгөөд 2017 онд дунд ангийн сурагчдад хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн бол 2018 онд орон нутгийн сургуулиудад, 2019 онд бага ангийн сурагчдад хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн байна.

Иргэний дүрэм¹¹¹

Энэхүү дүрмийн үзэл баримтлалын анх Их Британид 1991 онд үндэсний хөтөлбөр болгон хэрэгжүүлсэн бөгөөд 1997 онд Энэтхэгийн засгийн газар засгийн газрын хөтөлбөр болгон хэрэгжүүлсэн байна. Тус хөтөлбөр нь төрөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, стандартын талаарх үүрэг болон иргэдийн ёс зүй, ёс суртахууны талаарх харилцан ойлголцлын баримт бичиг юм.

Иргэний дүрэмд дараах 6 зарчим баримталдаг байна. Үүнд:

1. Чанар
2. Сонголт
3. Стандартууд
4. Үнэ цэн
5. Хариуцлага
6. Ил тод байдал

¹¹⁰ <https://ayurgyannyas.org/story/> “Бүх нийтийн ёс зүйн боловсрол” хөтөлбөр

¹¹¹ <https://prepp.in/news/e-492-citizens-charter-ethics-notes> Иргэний дүрэм (Энэтхэг)

Өнгөрсөн жилүүдэд Энэтхэгийн эдийн засгийн хөгжлийн салбарт томоохон ахиц дэвшил гарсан. (Сүүлийн 10 жилд 51.63%-65.38% хүртэл) Мөн Энэтхэгийн иргэд эрхийнхээ талаар илүү ухамсартай, соёлтой, мэдлэгтэй болсон. Энэхүү Иргэний дүрмийг зохион байгуулах хариуцах ажлыг Энэтхэгийн засгийн газрын Захиргааны шийтгэл, олон нийтийн гомдолыг шийдвэрлэх газар (DARPG) хариуцдаг байна.

Гандигийн ёс зүй (Махатма Гандигийн 11 зарчим)¹¹²

Энэтхэгийн эрх чөлөөний тэмцлийн нэрт удирдагч Ганди нь хүчирхийлэлгүй байх философи, хайр энэрэл, тэгш байдал, энх тайвны зарчмаараа дэлхий даяар алдартай улс төрч билээ. Түүний төрсөн өдөр буюу 10 дугаар сарын 02-ны өдрийг Энэтхэгийн ард түмэн үндэсний баяр болгон тэмдэглэж, Гандигийн сургааль, зарчим, номлолыг хойч үедээ дэлгэрүүлэн түгээдэг байна. Энэ Гандигийн 11 зарчим өнөөдөр ч гэсэн Энэтхэг гэлтгүй дэлхий даяар олон сая хүмүүсийг чиглүүлж, урам зориг өгсөөр байна. Гандигийн 11 зарчим:

1. **Truth (Satya) – Үнэн байх:** Ганди үнэнийг бусад бүх сайн чанарын үндэс, суурь гэж үздэг. Тэрээр хүн амьдралдаа үнэнийг хэлж, амьдралын бүхий л талаар үнэнийг эрэлхийлж, үнэнч шударга амьдрах ёстой гэж үздэг.
2. **Nonviolence (Ahimsa) – Хүчирхийлэлгүй байх:** Хүчирхийлэлгүй байх нь Гандигийн гүн ухааны гол цөм нь байсан. Энэ нь аливаа амьд биетийг бие махбод, оюун санааны хувьд дарамт, хүчирхийлэлгүй, эвтэй найртай амьдрахын төлөө хичээх явдал юм.
3. **Non-Stealing (Asteya) –Хулгай хийхгүй байх:** Бусдын эд хөрөнгийг хүндэтгэж, шударга байхыг эрхэмлэдэг. Хулгайн явдал, шунахайн сэдлээс зайлсхийж, өөрийн байгаа байдалд сэтгэл хангалуун байхыг хэлнэ.
4. **Chastity (Brahmacharya) – Цэвэр, ариун байх:** Ганди өөрийгөө хянах, амин чухал энергийг хадгалахад итгэдэг байв. Энэ утгаараа ариун явдал гэдэг нь гэр бүлгүй байх, бэлгийн үйл ажиллагааг хийхгүй байх гэж үздэг байв.
5. **Non-Possession (Aparigraha) – Өмчгүй байх:** байдал: Энэ нь хэт эд хөрөнгөөс татгалзаж, сэтгэл хангалуун байх, энгийн буюу минимализмыг дэмждэг.
6. **Control of Diet (Asaucha) – Амтанд шунахгүй байх:** Энэ нь ухаалаг хооллолт, цагаан хоолны дэглэмийн ач холбогдлыг онцолдог. Ганди хоол хүнсний сонголтыг бие махбодын олон оюун санааны цэвэр ариун байдлыг хадгалах хэрэгсэл мөн амьтадын амийг таслах байх сонголт гэж үзсэн.

¹¹² <https://testbook.com/articles/11-principles-of-mahatma-gandhi> Махатма Гандигийн 11 зарчим

7. **Fearlessness (Abhaya) – Айдасгүй байх:** Энэ нь хүмүүсийг зоригтой, тэсвэр хатуужилтай, бэрхшээлийг давах туулах сэдлийг өгдөг.
8. **Equality (Sarvodaya) – Энэ нь ялгаварлан гадуурхалтын эсрэг тэгш бус байдлыг арилгахын төлөө байдаг.**
9. **Bread Labor (Bhoodan) – Биеэр хөдөлмөрлөх:** Хөдөлмөрийн үнэ цэнийг мэдэрч, ялангуяа биеийн хүчний ажил нь ангийн ялгааг багасгадаг.
10. **Swadeshi (Self-Sufficiency) – Хөршийгөө дэмждэг байх:** Үндэсний үйлдвэрлэлийг дэмждэг. Энэ нь улс орны эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэх хэрэгсэл гэж үздэг.
11. **Removal of Untouchability (Sarva Dharma Samabhava) – Давхраажлыг арилгах:** Хүмүүсийн нийгмийн уг гарвалаас үл хамааран тэгш байдлыг түгээх, энэтхэг онцлогтой давхраажлыг арилгахыг уриалдаг.

2.7. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

Соён гэгээрэл гэдэг ойлголт нь 1700-аад онд үүссэн, дэвшлийг боомилсон бүтцийг даван туулах зорилгоор саруул ухаанаар сэтгэж, үйлдэх хөгжлийг хэлдэг байна. Соён гэгээрлийн хамгийн чухал таних тэмдэг бол “саруул ухаан”¹¹³-д үндэслэн үнэлгээ өгч, шийдвэр гаргах явдал юм. Нийгэм-улс төрийн хувьд, соён гэгээрлийн зорилго нь хувь хүний үйлдэх эрх чөлөө¹¹⁴ (эманзипац), боловсрол, иргэний эрх, ерөнхий хүний эрх, төрийн чиг үүрэг болох нийтийн ач тус (эрх ашиг) гэсэн ойлголтуудад зонхилон чиглэсэн байдаг байна. Соён гэгээрлийн давалгаанууд утга зохиол, гоо сайхны урлаг, 1776 оны америкийн хувьсгал, 1789 оны францын хувьсгал зэргээр улс төрд хүчтэй нөлөө үзүүлж, улмаар улс төр болон нийгмийн байгуулалтад үргэлжилсэн дэвшлийн үйл явц болон тогтсоноор соён гэгээрэл нь орчин үеийн билэг тэмдэг болсон юм. Улмаар соён гэгээрлийн уламжлал нь НҮБ-аас 1948 оны 12 дугаар сард баталсан “Хүний эрхийн ерөнхий тунхаглал”-д тусгалаа олж, тунхаглагдсан юм.¹¹⁵

Дотоод сэтгэлийн боловсролыг олгох тухай тусгайлан зохицуулсан хууль, дүрэм хэдийгээр байхгүй ч ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт ёсзүй, ёс суртахуун болон зан суртахуун ба иргэний боловсролын хичээлийн агуулгад тусгагдсан гэж үзэж болохоор байна. Дээрх хичээлүүд нь суралцагч, өсвөр үе, залуучууд өөрсдийн эрх, эрх чөлөөгөө мэдэж, шийдвэр гаргах үйл явцад оролцох, байр сууриа илэрхийлэх чадвараа хөгжүүлэхэд туслах, оролцоо бүхий нийгмийн хариуцлагатай гишүүн болон төлөвшихөд нь дэмжлэг үзүүлэх, залуучуудын ёс суртахууны ухамсар, ёс суртахууны зан байдлыг хөгжүүлэхэд чиглэж байна.

¹¹³ Vernunft-германаар

¹¹⁴ Emanzipation-германаар

¹¹⁵ Соён гэгээрэл-Aufklärung-германаар <https://de.wikipedia.org/wiki/Aufkl%C3%A4rung>

Дотоод сэтгэлийн боловсрол–нэр томьёоны хувьд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ойлголт байхгүй хэдий ч бусдыг энэрэн нигүүлсэх сэтгэл гэж ойлгоно. “Орчин үеийн боловсрол 200 гаруй жил хөгжиж, техник, технологи, материаллаг дэвшилд их анхаарч харин сэтгэлийн боловсролд сайн анхаарсангүй. Хүн хүнээ хайрлах, энэрэх дотоод сэтгэлийн боловсрол олгох хэрэгцээтэй болов.”¹¹⁶ Дотоод сэтгэлийн боловсролыг сүм хийд олгож ирсэн түүхэн уламжлалтай билээ. Азийн орнуудын хувьд, ёс суртахуун, иргэний боловсролын хичээл болон бусад хичээлийн хүрээнд шашны талаарх ойлголтыг өгдөг бол хичээлээс гадуурх хөтөлбөрийн хүрээнд, эсхүл хувийн сургуулиуд нь шашны сургалт явуулах эрхтэй байна. Харин европын хувьд, ерөнхий боловсролын хичээлийн хөтөлбөрт ёс суртахуун, иргэний боловсролын хичээлүүдээс гадна шашин судлалын хичээл орох нь харьцангуй түгээмэл байна. Европын 31 улсад судалгаа явуулахад, 14-т нь ёс суртахуун, зан суртахуунд чиглэсэн бие даасан хичээлийн хүрээнд заадаг бол 17 улс нь бусад хичээлийн судлах сэдвийн хүрээнд багтаасан байна.

Иргэний боловсрол хэмээх ойлголт нь хүүхэд, залуучуудыг нийгмийн идэвхтэй гишүүн болгон бэлтгэн хүмүүжүүлэх боловсролын салбар, харин иргэншлийн боловсрол нь тухайн нийгмийн гишүүд иргэн болон төлөвших үйл явцыг тэмдэглэсэн ойлголт гэж үздэг байна.¹¹⁷

НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага (ЮНЕСКО) бүх иргэн, хүн амын бүлэгт хүртээмжтэй хүний эрхийн боловсрол, сургалтын иж бүрэн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатайг гишүүн улс орнуудын анхааралд хүргэх, түүх, иргэний боловсрол зэрэг сургалтын хөтөлбөрт хүний эрхийн агуулгыг тусгаж, зөрчлийг энхийн замаар шийдвэрлэх, хүчирхийллийн бус стратегийг боловсруулах, улмаар тухайн боловсролын хөтөлбөрийн амжилт ололтыг гишүүн орон бүр 5 жил тутамд үнэлж байх талаар зөвлөмжийг 1987 онд гаргажээ.

Иргэний боловсролын талаар 1999 онд хэрэгжүүлсэн олон улсын харьцуулсан судалгаанаас үзэхэд, иргэний боловсролтой холбогдох зорилго, зорилтуудыг янз бүрээр тодорхойлдог хэдий ч дараах зорилтууд нийтлэг байна:

- Хувь хүний чадавх, бололцоог нэмэгдүүлэх;
- Тэгш бололцоог дэмжих;
- Залуу үеийг ажил хөдөлмөрт бэлтгэх;
- Цаашдын буюу дээд боловсрол эзэмших үндэс суурийг тавих;
- Мэдлэг, чадвар, ойлголт бий болгох;

¹¹⁶ О.Пүрэв “Боловсролын хүн судлал ба суралцагчийн хүмүүншил, хөгжил” Боловсролын хүрээлэн <https://humanities.mn/fileman/Uploads/Iltgel/2016-2017/hawar/3-purev.pdf>

¹¹⁷ “Иргэний боловсролын сургуулийн иргэний боловсролын сургалтад хийсэн үнэлгээ, мониторинг” Судалгааны тайлан, ННФ. УБ. 2011. 68-70 дахь тал

- Иргэншил буюу ардчилал ба нийтлэг хэм хэмжээнд суралцуулах;
- Соёлын өв уламжлалаа хадгалах, эдлэх явдал зэрэг болно.

Иргэний боловсрол нь хүний эрх, ардчилал, улс төр, иргэн-төрийн харилцаа, шийдвэр гаргах үйл явцын талаар мэдлэг эзэмших, чадвар, хандлагаа хөгжүүлэх үйл явцыг багтаасан, олон бүрэлдэхүүн хэсэг бүхий насан туршийн боловсрол юм. Иргэний боловсролын агуулгад мөн плюрализм, олон соёлт орчин, угсаатны ба соёлын өв уламжлал, нийгмийн ялгарал, хүлээцтэй хандах байдал, нийгмийн зүй ёс, үндэсний онцлог, ухаалаг байдал, байгаль орчны ач холбогдлын мэдрэмж зэрэг олон шинэлэг асуудал тусдаг байна. Хүн нийгмийн амьдралын олон талт харилцаанд оролцдог учир тухайн хүнд нийгмийн харилцааны үндэс суурь, зарчмууд, үүрэг хариуцлагын талаар тодорхой мэдлэг, ойлголт байх шаардлагатай. Тиймээс иргэний боловсролын хичээлийн агуулга нь улс төр, эдийн засаг, нийгэм, ёс суртахуун, соёлын гэсэн 5 үндсэн айн хүрээнд боловсрогдож, эдгээрийн талаар зохих мэдлэг, хандлага төлөвшүүлэхэд чиглэх нь зүйтэй хэмээн судлаачид үздэг байна.

«Иргэний боловсрол»-ын агуулгыг нийгмийн ухаан, нийгэм судлал, дэлхий судлал, хүн ба нийгэм, амьдралын ухаан, мэргэжлээр дэвших, хүний эрхийн боловсрол, ёс зүйн боловсрол, эрх зүйн боловсрол зэрэг олон хичээлийн хүрээнд улс орнууд өөрийн иргэддээ орчин үеийн нийгмийн улс төр, эдийн засаг, соёл, ёс суртахууны харилцааны үндсийг заан сургаж, тэдгээр харилцаанд үр ашигтай оролцох талаар зохих чадвар, хандлагыг төлөвшүүлж иржээ. Түүнээс гадна иргэний боловсрол нь түүх, газар зүй, эдийн засаг, улс төр судлал, байгаль орчин судлал, шашин судлал, төрөлх ба гадаад хэл зэрэг бусад хичээлүүдтэй харилцан холбогдож, иргэдийг нийгмийн харилцаанд бэлтгэхэд дэмжлэг үзүүлдэг байна.¹¹⁸

Герман Улсын ёс зүй, зан суртахууны боловсролын чиг хандлага нь баруун европ буюу бүс нутгийн хэмжээнд олон загвар, хандлага бүрэлдэн тогтсон улсад хамаарна. Муж улсуудын Боловсролын сайд нарын хуралдаанаас 1950 онд ерөнхий боловсролын дунд болон их, дээд сургуулийн иргэний боловсролын хичээлийн үндсэн зарчмыг “иргэний боловсрол нь сурагчдын ёс суртахууны ба нийгмийн хариуцлагатай гишүүний үйл, үйлдлийн ухамсрыг төрүүлэх ёстой” хэмээн тогтоосон байна.

Боловсролын хөтөлбөрийн хүрээнд ёс зүй, ёс суртахуун, зан суртахууны хичээлийн сэдвийг бие даасан хичээл байхаар тогтсон бөгөөд

- ёс зүй;
- амьдрах гүн ухаан - ёс зүй;

¹¹⁸ Д.Халиун нар “Хүүхэд, залуучуудын хүмүүжил, төлөвшил, ёс суртахууны боловсролын талаарх бусад орны туршлага” СТ-18/211 Судалгаа, мэдээлэл, лавлагааны алба, УИХТГ 2019

- хүүхэд нас, үнэт зүйл, хэм хэмжээний гүн ухааны хичээлийг заавал судлах буюу заавал судлах/сонгон судлах хэлбэрээр, харин
- шашин судлалын хичээлийн шашны нэг гол урсгалд чиглэсэн хөтөлбөр (хичээлийн агуулга, сургалтын материал боловсруулахад шашны нийгэмлэгүүд голлох үүргийг гүйцэтгэнэ)-ийг заавал судлах буюу заавал судлах/сонгон судлах хэлбэрээр, аль нэг шашны урсгалд чиглээгүй, шашны талаар ерөнхий ойлголт олгох (төр буюу сургууль нь төвийг сахисан байр сууринаас, хүний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хүндэтгэж, сургалтыг явуулна) хөтөлбөрийг нэмэлт хичээлийн хэлбэрээр тус тус зохион байгуулдаг байна.

Герман Улсын дунд сургуулийн нийгмийн ухаан, гүн ухааны хичээлийн хөтөлбөр дэх хэм хэмжээний харьцуулалтыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 5. Ёс суртахууны хэм хэмжээ, ёс зүйн хэм хэмжээ ба конвенц (нэгдмэл байдал)¹¹⁹

Е р ө н х и й ойлголт	“Хэм хэмжээ” (латинаар “дүрэм”) гэж харилцан үйлдлийн журмыг хэлнэ. Тэрээр тодорхой үйлдэл хийхийг зөвшөөрөх буюу хориглохыг илэрхийлнэ.		
Төрөл	ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ	ЁС СУРТАХУУНЫ ХЭМ ХЭМЖЭЭ	КОНВЕНЦ (НЭГДМЭЛ БАЙДАЛ)
Тодорхойлолт	(тодорхой нөхцөлд) ямар үйлдлийг хориглох буюу хийвэл зохих, болон зөвшөөрөх эсэхийг хуулиар (тодорхой) тогтоосон дүрэм	(тодорхой нөхцөлд) ямар үйлдэл зохих, хориглох буюу зөвшөөрөх талаарх дүрэм	(тодорхой нөхцөлд) нэгдмэл сонирхолтой хүмүүсийн бүлэгт (тухайлбал, уламжлал, зан заншил, соёл, шашин) мөрдөгдөх дүрэм
Хамрах хүрээ	<ul style="list-style-type: none"> - Улс төрийн тодорхой газар нутгийн хүрээ (тухайлбал, ХБНГУ, муж улс) - Хүмүүсийн тодорхой бүлэг (тухайлбал, 18 нас хүрсэн Герман Улсын иргэн сонгуулийн эрхтэй) - Бүх хүн (тухайлбал, амьд явах хүний эрх) 	<ul style="list-style-type: none"> - Бүх хүн (тухайлбал, худал хэлэхийг хориглох) 	<ul style="list-style-type: none"> - Тодорхой бүлэг хүмүүс (тухайлбал, тодорхой шашны гишүүн мөргөлчдийн дүрэм; тодорхой соёл дахь мэндлэх дүрэм)

¹¹⁹ Ёс суртахууны хэм хэмжээ, ёс зүйн хэм хэмжээ ба конвенц (нэгдмэл байдал)-Moralische Normen, rechtliche Normen und Konventionen-германаар <https://www.schule-bw.de/faecher-und-schularten/gesellschaftswissenschaftliche-und-philosophische-faecher/ethik/methodik-didaktik/methodik-ethik/normen-und-konventionen-info.pdf>

Хэм хэмжээг зөрчсөнөөр хүлээх хариуцлага	<ul style="list-style-type: none"> - Гэмт хэргийн бүртгэл - Гэмт хэргийн мөрдлөг - (болзошгүй) Шийтгэл (тухайлбал, мөнгөн торгууль, баривчлах ял, нийгмийн тустай хөдөлмөр) 	<p>Тухайлбал,</p> <ul style="list-style-type: none"> - Ичих (өөрийн хийсэнд) - Шаналах (өөрийн хийсэнд) - Нийгмийн жигшил - Доромжлох - Үл итгэх 	<p>Тухайлбал,</p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн гадуурхал (тухайлбал, хөмсөг зангидах, жаахан ханиах /”хм” гэх/, басамжилж харах) - Загнах
Жишээ	<ul style="list-style-type: none"> - “нийтийн тээвэрт туулайчлах хориотой” - “улаан гэрэл асч байхад гарцаар гарахыг хориглоно” - “зовсон хүнд өөрийн боломжийн хэрээр үл туслах нь гэмт хэрэг мөн” 	<ul style="list-style-type: none"> - “худал ярьж болохгүй” - “шаардлагагүй бол хог гаргахгүй байх хэрэгтэй” - “зөрчлийг эвийн аргаар шийдэх нь зүйтэй” 	<ul style="list-style-type: none"> - “хэрэв чи бэлэг авсан бол гялайснаа илэрхийлэх хэрэгтэй.” - “их дэлгүүрийн кассчинтай мэндлэх нь зохимжтой” - “дарааллын урдуур дайрах нь хүндэтгэлгүй хэрэг”

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Сингапур Улс

- <https://www.nlb.gov.sg/main/article-detail?cmsuuid=99663443-930d-418e-b010-4718d0ad7543>
- <https://www.moe.gov.sg/education-in-sg/our-programmes/national-education>
- <https://www.nlb.gov.sg/main/article-detail?cmsuuid=fa092bc5-6339-4c60-beb2-b6355d6027cc>
- <https://www.nlb.gov.sg/main/article-detail?cmsuuid=c78526c6-decf-4b79-b4ca-421739464884>
- <https://values-in-practice.com/>
- <https://www.sgjourney.gov.sg/>
- <https://www.sgjourney.gov.sg/pdfs/welcome-to-singapore/>

Эстони Улс

- https://link.springer.com/content/pdf/10.1007/978-3-030-71102-3_7.pdf
- <https://www.jsse.org/index.php/jsse/article/view/5368>
- <https://eetika.ee/en/content/ethics-estonia>
- <https://eetikakeskus.ut.ee/en/content/about-centre-ethics>
- <https://euroguidance.eu/guidance-system-in-estonia>
- <https://www.educationestonia.org/innovation/>
- https://www.educationestonia.org/wp-content/uploads/2022/12/haridusvaldkonna_arengukava_2035_kinnittaud_vv_eng_0-1.pdf
- https://national-policies.eacea.ec.europa.eu/sites/default/files/2023-04/Estonia_2021.pdf
- <https://valitsus.ee/en/estonia-2035-development-strategy/necessary-changes/sustainability-nation-health-and-social>
- Гадаадын зарим орны бага, дунд боловсролын тогтолцоо ба үндэсний өв, соёлыг сургалтын агуулга, хөтөлбөрт тусгасан байдлын талаарх харьцуулсан судалгаа (СТ-18/210). Д.Халиун, Б.Нандингэрэл, И.Жаргалзаяабямба. УИХТГ-ын ПССХ-ийн Судалгааны алба. 2018 он.

Япон Улс

- Social Education Law <https://www.hurights.or.jp/archives/asiapacific/section1/pdf/Social%20Education%20and%20Kominkan.pdf>
- Basic Plan for the Promotion of Education <https://www.mext.go.jp/en/policy/education/lawandplan/title01/detail01/1373797.htm>
- Moral education in Japan <https://www.nier.go.jp/English/>

educationjapan/pdf/201303MED.pdf

- Japanese educational system <https://www.studyinjapan.go.jp/en/planning/educational-system/>
- Social Education in Japan https://www.mext.go.jp/component/a_menu/education/detail/
- Japan overview of the education (EAG 2023) <https://gpseducation.oecd.org/CountryProfile?primaryCountry=JPN&treshold=10&topic=EO>
- Social education and social work in Japan <https://journals.uclpress.co.uk/ijsp/article/pubid/IJSP-10-12/>

Солонгос Улс

- БНСУ-ын Боловсролын яам <https://english.moe.go.kr/sub/infoRenewal.do?m=0302&page=0302&s=english>
- 2020 Education in Korea <http://koreaneducentreinuk.org/wp-content/uploads/2021/04/2020EducationinKorea.pdf>
- The National Curriculum for the Primary and Secondary Schools <http://koreaneducentreinuk.org/wp-content/uploads/2021/02/The-National-Curriculum-for-the-Primary-and-Secondary-Schools-2015.pdf>
- global Citizenship Education in South Korea through Civil Society Organizations: Its Status and Limitations <https://s-space.snu.ac.kr/bitstream/10371/110049/1/4.%20심희정.pdf>
- Civic Education and Political Empowerment Among South Korean Youth <https://stacks.stanford.edu/file/druid:nw989rf6654/Han%20-%20Civic%20Education%20and%20Political%20Empowerment%20Among%20South%20Korean%20Youth.pdf>
- БНСУ-д амьдрах иргэдэд зориулсан гарын авлага www.liveinkorea.kr

Казахстан Улс

- Конституция Республики Казахстан. (принята на республиканском референдуме 30 августа 1995 года) (с изменениями и дополнениями по состоянию на 23.03.2019 г.) <http://online.zakon.kz>
- Закон о государственной службе Республики Казахстан от 23 ноября 2015 года. (с изменениями и дополнениями по состоянию на 11.01.2021 г.) <http://online.zakon.kz>
- “Об утверждении Реестра должностей политических и административных государственных служащих” Указ Президента Республики Казахстан от 29.12.2015 года № 150. <https://adilet.zan.kz/rus/docs/U1500000150>
- “Об утверждении квалификационных требований к отдельным

политическим государственным должностям” Указ Президента Республики Казахстан от 31.12.2020 года № 485. <https://adilet.zan.kz/rus/docs/U2000000485>

- Пралиев С.Ж. Үндэсний хүмүүжил. Сборник лекции. Алматы. КазНПУ имени Абая. Алматы 2011 г.

Энэтхэг Улс

- <https://timesofindia.indiatimes.com/blogs/india-to-bharat/is-the-national-education-policy-focused-on-making-enlightened-and-responsible-citizens/>
- <https://ayurgyannayas.org/story/> “Бүх нийтийн ёс зүйн боловсрол” хөтөлбөр
- <https://prepp.in/news/e-492-citizens-charter-ethics-notes> Иргэний дүрэм (Энэтхэг)
- <https://testbook.com/articles/11-principles-of-mahatma-gandhi> Махатма Гандигийн 11 зарчим
- <https://timesofindia.indiatimes.com/blogs/india-to-bharat/is-the-national-education-policy-focused-on-making-enlightened-and-responsible-citizens/>

Герман Улс

- Соён гэгээрэл-Aufklrung-германаар
<https://de.wikipedia.org/wiki/Aufkl%C3%A4rung>
- О.Пүрэв “Боловсролын хүн судлал ба суралцагчийн хүмүүншил, хөгжил” Боловсролын хүрээлэн, 2017
<https://humanities.mn/fileman/Uploads/Iltgel/2016-2017/hawar/3-purev.pdf>
- “Иргэний боловсролын сургуулийн иргэний боловсролын сургалтад хийсэн үнэлгээ, мониторинг” Судалгааны тайлан, ННФ 2011. 68-70 дахь тал
- Д.Халиун нар “Хүүхэд, залуучуудын хүмүүжил, төлөвшил, ёс суртахууны боловсролын талаарх бусад орны туршлага” СТ-18/211 Судалгаа, мэдээлэл, лавлагааны алба, УИХТГ 2019

УИХМН
СУДАЛГААНЫ САН